



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/269

Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5 дахь заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр заавар"-ыг нэгдүгээр, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний түр заавар"-ыг хоёрдугаар, "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөх халдварын сэргийлэлт, хяналтын түр заавар"-ыг гуравдугаар, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдваргүйжүүлэлт хийх түр заавар"-ыг дөрөвдүгээр, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-ыг тавдугаар, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судалгааны хуудас"-ыг зургаадугаар, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын ажиглалтын хуудас"-ыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан түр зааврыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Наранзул/-д, харьяа эрүүл мэндийн байгууллагыг нэгдсэн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээг сайжруулах ажлыг уялдуулан хариуцсан чиг үүргийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 07 сарын 19-ны өдрийн тушаалын
нэгдүгээр хэсгээр 19

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН ТҮР ЗААВАР

Нэг. Үндэслэл

2019 оны 12 дугаар сарын сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубей мужийн Ухань хотод шалтгаан тодорхойгүй уушгины хатгаа өвчний дэгдэлт бүртгэгдэж, 2020 оны 1 дүгээр сарын 7-нд шинэ төрлийн коронавирус (SARS-CoV-2)-ээр үүсгэгдсэн болохыг тогтоосон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг "Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал", 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр "Цар тахал" хэмээн зарласан.

Мөн ДЭМБ-ын мэргэжлийн зөвлөх багийн 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг өвчнийг "КОВИД-19" хэмээн нэрлэж, олон улсын өвчний 10 дугаар ангиллаар U07.1 кодоор бүртгэж эхэлсэн.

Манай улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Коронавируст халдвар (КОВИД-19)-ын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол, 11 дүгээр сарын 11-ний өдөр хүн амын "дотоодын халдвар" анх бүртгэгдсэн талаар зарласан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд энэхүү түр заавар болон бусад холбогдох дүрэм, журмыг баримтална. ДЭМБ-аас зөвлөмж болгосон коронавируст халдвар (КОВИД-19)-ын түр заавар шинэчлэгдэх бүрт энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт орно.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судлал

2.1. Үүсгэгч

Coronaviridae овгийн Бета-коронавирусийн бүлгийн дан утаслаг РНХ агуулсан вирус.

2.2. Үүсгэгчийн тэсвэрлэх чадвар

2.2.1. SARS-CoV-2 вирусийн тэсвэрлэх хугацаа нь орчны агаарын хэм, чийглэг зэргээс хамаарна. Уг вирус нь өвчтөний амьсгалын замаас ялгарсан аэрозолд 3 цаг, 40%-ийн агаарын чийгшилтэй нөхцөлд 21-23°C хэмд зэс, ган, цаас, хуванцар эдлэлийн гадаргууд 7-оос дээш хоног тэсвэртэй.

2.2.2. Дэлхийн улс орнуудын судалгаагаар үүсгэгч нь тасалгааны хэмд модон болон хөвөн эдлэлийн гадаргууд 24 цаг, арьсан эдлэлд ≥ 24 цаг, барилгын хананы

шохой, цаасанд 36 цаг, хуванцар эдлэлийн гадаргууд 36-72 цаг, ган эдлэлийн гадаргууд 72 цаг, шилэн эдлэлийн гадаргууд 96 цаг хүртэл тэсвэртэй.

2.2.3. Өвчтөний өтгөн, шээсэнд тасалгааны хэмд 1-2 өдөр, суулгах шинж тэмдэг илэрсэн өвчтөний өтгөнд 4 хоног хүртэл хадгалагдаж, өргөн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлсний дараа халдварлуулах идэвхээ богино хугацаанд алддаг.

2.3. Халдварын эх уурхай

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэгтэй болон шинж тэмдэггүй хэлбэрээр өвчилсөн хүн.

2.4. Халдвар дамжих зам

2.4.1. Дуслын болон шууд хавьтлын зам: Өвчтэй хүн ярих, ханиах, найтаах, дуулах зэрэгт амьсгалын замаас 5-10 μ m хэмжээтэй вирус агуулсан дусал өвчтөний эргэн тойрны 1 метр хүртэлх зайд цацагдах ба дараахь тохиолдолд эрүүл хүний ам, хамар, нүдний салстаар халдвар дамжина. Үүнд:

- Өвчтэй хүний биед хүрэлцэх эсвэл нэг метр хүртэлх зайд харьцах;
- Эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцас, хэрэгсэлгүй эсвэл бүрэн бус хамгаалах хувцас хэрэгсэлтэй өвчтөнг асарч сувилах, эмчилгээ хийх;
- Аэрозол үүсгэх ажилбарууд хийх, амьсгал, зүрх зогссон үед сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Шаардлага хангахгүй агааржуулалттай, битүү орчин, өрөө, тасалгаанд SARS-CoV-2 вирус агуулсан ≤ 5 μ m хэмжээтэй мананцар агаарын хөдөлгөөнөөр хол зайд тархаж, халдварлуулах эрсдэлтэй. Зарим улсад лабораторийн нөхцөлд хийгдсэн туршилтаар SARS-CoV-2 вирусийн PHX нь агаарт 3-16 цаг хадгалагдаж байгааг тогтоосон.

2.4.2. Шууд бус хавьтлын зам: Өвчтэй хүний хэрэглэж байгаа, хэрэглэж байсан болон эргэн тойрны эд юмс, биологийн шингэн, цус, эмнэлгийн тусламж үзүүлэх үед ашигласан багаж, тоног төхөөрөмж зэргээс халдвар дамжина.

2.4.3. Өтгөн мөр-амны зам болон амьтнаас хүнд дамжин халдварлах боломжтой.

2.5. Нууц үеийн хугацаа

Нууц үеийн хугацаа 1-14 хоног, дунджаар 5-6 хоног байна.

2.6. Халдвартай байх үе

Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 1-3 хоногт, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгээс хамаарч, 10-14 хоногт, дархлаа дарангуйлагдсан өвчтөн >14 хоногт халдвар тарх эрсдэлтэй.

2.7. Халдварт өртөх эрсдэлтэй хүн ам

2.7.1. Бүх нас, хүйсний хүн өртөх эрсдэлтэй.

2.7.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй 1-2 метрээс дотогш зайд харьцаж, биед нь шууд хүрэлцсэн хүн, тухайн өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн ажилтан, нэг тасагт хэвтэн эмчлүүлж байгаа бусад өвчтөн,

багтрааны улмаас тогтмол эм хэрэглэдэг өвчтөн, зүрх судас, уушги, бөөр, элэг, цус, мэдрэлийн архаг өвчтэй, чихрийн шижинтэй, эрхтэн шилжүүлэн суулгуулсан, ДОХ ба бусад дархлаа дутмагшилтай, хорт хавдартай өвчтөн, жирэмсэн эх, таргалалт болон бусад суурь өвчтэй хүн, 60-аас дээш насныхан өртөх өндөр эрсдэлтэй.

2.8. Тохиолдлын тодорхойлолт

2.8.1. Сэжигтэй тохиолдол

А. Эмнэлзүйн шалгуур:

1. Халуурах, ханиалгах зэрэг амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг илэрсэн ЭСХҮЛ
2. Халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд зам үрэвсэх, үнэр, амт мэдрэхгүй байх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох зэрэг эмнэлзүйн шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрсэн;

Тархвар судлалын шалгуур:

1. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө Коронавируст халдвар (КОВИД-19) тархах өндөр эрсдэлтэй тусгаарлан ажиглах байр, олон хүнийг нэг дор байршуулсан нийтийн байр зэрэгт ажиллаж эсвэл амьдарч байсан ЭСХҮЛ
2. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө Коронавируст халдвар (КОВИД-19) хүн амын дунд өргөн тархсан газарт амьдарч байсан буюу аялсан ЭСХҮЛ
3. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 14 хоногт эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан эсхүл үйлчлүүлж байсан;

Б. Тархвар судлалын холбогдолгүй боловч амьсгалын замын цочмог хүнд халдвартай, сүүлийн 10 хоногт өвчин эхэлж, 38°C хэм болон түүнээс дээш халуурч, ханиалгасан, зайлшгүй эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай;

В. Тархвар судлалын хувьд холбогдолгүй, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй боловч SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар эерэг тодорхойлогдсон тохиолдлыг хэлнэ.

2.8.2. Магадлалтай тохиолдол

А. Дээрх эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрсэн бөгөөд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолтой хавьтал болсон, тархвар судлалын хувьд батлагдсан тохиолдлын голомтод хамаарах SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар эерэг тодорхойлогдсон;

Б. Дүрс оношилгоогоор уушгинд дараахь шинжээс аль нэг нь илэрсэн. Үүнд:

- Цээжний рентген зурагт уушгины доод дэлбэнгийн захаар байрласан дугариг нэвчдэст сүүдэр илэрсэн;
- Цээжний компьютерт томографийн шинжилгээнд уушгины доод дэлбэнгийн захаар байрласан дугариг нэвчдэст сүүдэр буюу хоёр талыг хамарсан олон тооны бүдэг нэвчдэс "Бүүдгэр шилний шинж" илэрсэн;

- Уушгины хэт авиан шинжилгээнд зузаарсан гялтан хальсны шугам, Б шугам (олон тооны, нийлмэл болон салангад), гуурсан хоолойн зураглалтай болон зураглалгүй нийлмэл өөрчлөлт илэрсэн.

В. Ямар нэг шалтгаангүйгээр гэнэт үнэр эсвэл амт мэдрэхгүй болсон;

Г. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан тохиолдолтой хавьтал болсон, тархвар судлалын хувьд батлагдсан тохиолдлын голомтод хамаарах шалтгаан тодорхойгүй амьсгалын дистресс хам шинжээр нас барсан тохиолдлыг хэлнэ.

2.8.3. Батлагдсан тохиолдол

Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран бодит хугацааны Полимеразийн гинжин урвал (бх-ПГУ)-ын шинжилгээгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-тай болох нь тогтоогдсон тохиолдлыг хэлнэ.

2.9. Хавьтал

2.9.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхийн өмнөх 2 хоногт, шинж тэмдэг илэрсэнээс хойшхи 14 хоногийн хугацаанд хавьтал болсон ЭСХҮЛ;

Эмнэлзүйн шинж тэмдэггүй боловч лабораторийн шинжилгээгээр онош батлагдахын өмнөх 2 хоногоос сүүлийн 14 хоногийн хугацаанд хавьтал болсон хүнийг тооцно.

2.9.2. Хавьтлыг халдварт өртөх эрсдэлээр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

2.9.2.1. Эрсдэл өндөртэй 1-р хавьтал:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй нэг өрх, нийтийн болон дотуур байрны нэг өрөө, цэргийн хуаранд хамт амьдардаг хүн;

2. Хамгаалах хувцас, хэрэгсэлгүйгээр гар барих, тусламж үзүүлэх, асрах зэргээр Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөний биеийн аль нэг хэсэгт шууд хүрэлцсэн хүн;

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөний биологийн шингэн болон тэдгээрийг арчиж, цэвэрлэсэн цэвэрлэгээний материалд хамгаалах хувцас, хэрэгсэлгүйгээр шууд хүрэлцсэн хүн;

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй 2 хүртэлх метрийн зайд 15 минут болон түүнээс дээш хугацаанд харьцсан хүн;

5. Хичээлийн анги танхим, уулзалтын өрөө, эмнэлгийн хүлээлгийн хэсэгт Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй 2 хүртэлх метрийн зайд 15 минут ба түүнээс дээш хугацаанд харьцсан хүн;

6. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх, шинжилгээ авах үед шаардлага хангасан хувийн хамгаалах хувцас өмсөөгүй эсвэл тусламж, үйлчилгээ үзүүлэх үед хамгаалах хувцасны бүрэн бүтэн байдал алдагдсан эрүүл мэндийн ажилтан;

7. Нэг тээврийн хэрэгсэл буюу галт тэрэгний нэг тасалгаа, нийтийн галт тэрэг, автобус, суудлын автомашинд суусан бүх зорчигч, нисэх онгоцны урд, хойд, хажуугийн 3 эгнээнд суусан зорчигч, үйлчилгээ үзүүлсэн ажилтан.

2.9.2.2. Эрсдэл багатай 1-р хавьтал

1. Нэг орц, нийтийн болон дотуур байрны нэг хонгилд (коридор) амьдардаг, ариун цэврийн болон бие засах нэг, өрөө ашигладаг нийтийн байранд амьдардаг хүмүүс;

2. Нийтийн хоолны газарт, нэг цаг хугацаанд зэргэлдээ ширээ (ойролцоо), байршилд хоол идсэн хүмүүс;

3. Халдвартай нь тогтоогдсон хүний халдваргүйтгээгүй орчны эд зүйлд хүрэлцсэн өгүүлэмжтэй хүмүүс;

4. Агааржуулалт муутай, битүү орчинд (автобус, цахилгаан шат, нисэх онгоц, галт тэрэг) эрсдэл өндөртэй 1 дүгээр хавьтлаас (эрсдэл өндөртэй 1-р хавьтлын 7-рт заалт) хол зай байрлалд байсан хүмүүс;

5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын онош батлагдахаас өмнө өвчтэй, халдвартай хүний үйлчлүүлсэн эрүүл мэндийн болон бусад байгууллагад очсон гэх тархвар судлалын өгүүлэмжтэй хүмүүсийг оруулж тооцно.

2.9.2.3. Хоёр дугаар хавьтал

Эрсдэл өндөртэй, багатай 1-р хавьталтай харьцсан хүмүүсийг хэлнэ.

Гурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын бэлэн байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

3.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тандах, эрт илрүүлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний журам, зааврыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлын хэсэг, мэргэжлийн багийг байгуулах;

3.1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн бэлэн байдлын нөөцийг үнэлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар УИХ, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.6. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, оношлуур, урвалж, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;

3.1.7. Нэмэлтээр дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтны судалгааг гаргаж, сургалтад хамруулсан байх;

3.1.8. Резидент эмч, анагаахын чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн оюутны судалгааг гарган, дайчлан ажиллуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар хүн амыг нэгдсэн мэдээллээр хангах;

3.1.10. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг чиглүүлэх, коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх албан ёсны мэдээллээр олон нийтийг хангах;

3.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв:

3.2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх, мэргэжлийн анги, тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх;

3.2.2. Томуу, томуу төст өвчин болон амьсгалын замын цочмог хүнд халдварын тандалтыг эрчимжүүлэх;

3.2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, тандах, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр журам, зааврын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх;

3.2.4. Өвчлөлийн нөхцөл байдал болон ДЭМБ-ын түр заавар, удирдамжтай уялдуулан тандалт, хариу арга хэмжээний зааврыг тухай бүр шинэчлэх;

3.2.5. Үндэсний түвшинд коронавируст халдвар (КОВИД-19)-ын хяналт-тандалтын чиглэл гаргах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний журам, зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах;

3.2.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэгт хяналт хийх;

3.2.7. Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх арга хэмжээ, тандалт, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн хэрэгжилтийг мэргэжил аргазүйгээр хангах, арга хэмжээ авах;

3.2.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан салбар хоорондын байгууллагуудтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшин, идэвхжлийн зэргээс хамаарч, хариу арга хэмжээг зохион байгуулах;

3.2.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай тохиолдлоос сорьц цуглуулж, лабораториор баталгаажуулах;

3.2.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн даруйд томилогдсон ажилтан ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн эрүүл мэнд, хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт сэргийлэлтийн хэлтэс, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабын даргад нэн даруй мэдээлэх;

3.2.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай тохиолдлыг судлах, батлагдсан тохиолдлын эх уурхай, 1 болон 2-р хавьтал, голомтын цар хүрээг тодорхойлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.12. Коронавируст халдварын сэжигтэй, магадлалтай батлагдсан тохиолдлын нарийвчилсан тархвар судлалын судалгаа, 1,2-р хавьтлын шинжилгээг хийж, нэгтгэн мэдээлэх;

3.2.13. КОВИД-19 судалгааны баг нь Монгол улсад гарсан коронавируст халдварын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 7 хоног бүр эргэн мэдээллээр хангах;

3.2.14. Шинэ болон дахин сэргэж байгаа халдварын болон тусгай тасгийн бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн орны зохицуулалт хийн, нэмэлтээр ор дэлгэж, сэжигтэй болон батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.2.15. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажиллах шуурхай хариу арга хэмжээний болон тусламж, үйлчилгээний багийг томилон ажиллуулах, сургах, хамгаалах хувцас, хэрэгслээр тасралтгүй хангах;

3.2.16. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын өвчлөлийн байдалд дүн шинжилгээг тогтмол хийж, хариу арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах;

3.2.17. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах;

3.2.18. Тусгаарлах, ажиглах байрны халдварын сэргийлэлт, хяналтын байдалд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.19. Аймаг, нийслэл, хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн улсын байцаагч, ажилтанд халдвараас сэргийлэх дэглэм, хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.20. Халдварын сэжигтэй тохиолдол Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх агаарын хилийн боомт, олон улсын төмөр зам, гаалийн хяналтын бүсэд илэрсэн үед мэргэжлийн багийг илгээж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд орон нутагт мэргэжлийн багийг илгээх;

3.2.21. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, оношилгоо, эмчилгээний талаарх сургалтыг эрүүл мэнд, мэргэжлийн хяналт болон холбогдох байгууллагыг оролцуулан зохион байгуулах;

3.2.22. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх албан ба албан бус мэдээллийг шүүх, иргэдэд мэдээлэл өгөх 80086829 утсыг 7/24 цагаар ажиллуулж, иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ташаа мэдээллийг залруулах, олон нийтийн хандлагыг судлах;

3.2.23. Хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх, тогтмолжуулах;

3.3. Зоонозын өвчин судлалын үндэсний төв:

3.3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх, мэргэжлийн анги, тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх;

3.3.2. Халдварт өвчний бэлэн байдлын улсын хэмжээний нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай үед нөхөн хангалт хийх;

3.3.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед суурин болон явуулын вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх, үр дүнг мэдээлэх;

3.3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүн амын дундах өргөжүүлсэн тандалт хийхэд оролцох, лабораторийн шинжилгээ хийх, үр дүнг мэдээлэх;

3.3.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийх талаар тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах, зохицуулалт хийх;

3.3.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах;

3.3.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдварын үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах;

3.3.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэм, халдваргүйжүүлэлтийн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

3.3.9. Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтын болон эцсийн халдваргүйжүүлэлтийн давтан болон дадлагажуулах сургалт хийх;

3.3.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлоос судалгаа авч хэрэв тэжээвэр амьтантай бол мал эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагатай хамтран тандалт судалгаа хийх;

3.3.11. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийг гарган, бэлэн байдлыг хангах, хэрэглэх зааврыг боловсруулах;

3.3.12. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хийгдэх халдваргүйжүүлэлтийн талаар эрүүл мэндийн болон салбар хоорондын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах;

3.3.13. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар албан ба албан бус мэдээллийг шүүх, иргэдэд мэдээлэл өгөх 70284393 утсыг 7/24 цагаар ажиллуулж иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ташаа мэдээллийг залруулах олон нийтийн хандлагыг судлах.

3.4. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв:

3.4.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх Коронавируст халдвар (КОВИД-19) тандалтын баг нь халдвар тархалтын үе шат бүрт байнгын үйл ажиллагаатай байгаа өндөр эрсдалтэй аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдын дунд идэвхтэй тандалт, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын дундах идэвхтэй тандалт судалгааг тусгайлсан удирдамжийн дагуу хийж, үр дүнг мэдээлэх;

3.4.2. Үндэсний түвшинд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн шинжилгээний мэдээ, үр дүнг нэгтгэж, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

3.4.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, урьдчилан сэргийлэлтийн талаар сургалт зохион байгуулах;

3.4.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хүн амын дундах ойлголт, хандлагыг тандаж, тухай бүр нь хариу арга хэмжээ авах;

3.4.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тандалт, судалгаа, хяналт хийж, тухай бүр тайлбар, залруулга, мэдээлэл хийх;

3.4.6. Эрсдэлийн харилцаа холбоог эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх;

3.4.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 119 тусгай дугаарын утсыг 7/24 цагаар ажиллуулах.

3.5. Нийслэлийн эрүүл мэндийн газар

3.5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

3.5.2. Нийслэлийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эрсдэл багатай 1-р хавьтал болон 2-р хавьтлыг судалж, эрүүл мэндийг хянах;

3.5.3. Автозамын хяналтын постоор орж гарч байгаа зорчигчийн эрүүл мэндийн байдлыг хянах;

3.5.4. Түргэвчилсэн оношилгооны цэг байгуулан ажиллах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.5.5. Сорьц авах цэгээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шалтгаанаар шинжилгээ өгч байгаа иргэний өвчний карт эсвэл 13А маягтанд хэвтэх өдрийг тэмдэглэж, эмчийн тамгаар баталгаажуулсныг үндэслэн тухайн иргэний шинжилгээний сорьцонд "Яаралтай" тэмдэглэгээ тавьж лабораторид хүргэнэ.

3.6. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага:

3.6.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

3.6.2. Томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын тандалтыг эрчимжүүлэх;

3.6.3. Халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.6.4. Эрүүл мэндийн байгууллага бүр эрсдэлийг үнэлж, халдварын эрсдэл өндөртэй цэг, байршил, ажлын байрыг илрүүлж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах;

3.6.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, эмчлэх өрөөг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу зохион байгуулах;

3.6.6. Эрүүл мэндийн ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох ажлыг хариуцах, багийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах;

3.6.7. Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчдийг эмнэлэгт суурилсан идэвхтэй тандалт судалгаанд хамруулах;

3.6.8. Төлөвлөгөөт журмаар хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэний өвчний карт эсвэл 13А маягтанд хэвтэх өдрийг тэмдэглэж, эмчийн тамгаар баталгаажуулах;

3.6.9. Үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудын дунд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж хүн тус бүрээр тэмдэглэл хөтлөх;

3.6.10. Эрүүл мэндийн байгууллага Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх өөрийн багийн гишүүдийн биоаяулгүй ажиллагааг хангах, халдварт өртөх эрсдэлээс хамгаалах;

3.6.11. Эрүүл мэндийн ажилтныг хувийн хамгаалах хувцас, багаж хэрэгсэл, бодис, эм, урвалжаар хангах;

3.6.12. Үйлчлүүлэгчдийн үзлэгийн цагийг цахим болон утсаар олгож цагаа баримталж үйлчлэх;

3.6.13. Үйлчлүүлэгчдийн биеийн халууныг хэмжиж, QR код эсвэл үйлчлүүлэгчийн овог нэр, регистрийн дугаар, утас, оршин суугаа хаягийн бүртгэл хийх;

3.6.14. Үйлчлүүлэгчийн эмнэлэгт ирэх хөдөлгөөнийг бууруулж, байнгын хяналтад байдаг зорилтот бүлгийн иргэнд цахимаар зөвлөгөө өгөх, хяналт тавих, гэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх зохицуулалт хийх;

3.6.15. Өвчтний өрөөнд орох эмнэлгийн ажилтны тоог хязгаарлах, орсон гарсан хүний бүртгэл хөтлөх;

3.6.16. Халдварын сэжигтэй тохиолдол харьяа нутаг дэвсгэр, хилийн боомтод илэрвэл мэргэжлийн багийг илгээж, хариу арга хэмжээг салбар хоорондын байгууллагуудтай хамтран шуурхай авч хэрэгжүүлэх;

3.6.17. Хөтөч ажилтанг ажиллуулж, халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзлэгийн өрөө рүү чиглүүлэн, бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлэх;

3.6.18. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хүнд зай барих, амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахиу, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулга өгөх;

3.6.19. Амбулатори, хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт хэт ачаалал үүсэхээс сэргийлж, эмнэл зүйн шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг бусад үйлчлүүлэгчээс тусад нь хүлээн авах бүстэй байхаар зохион байгуулах;

3.6.20. Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг эрт илрүүлэх, оношлох чиглэлээр эрүүл мэндийн ажилтан бүрийг сургасан байх;

3.6.21. Халдварын сэргийлэлт, хяналтын байнгын болон нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.22. Эрүүл мэндийн ажилтанг коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлж, хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисоор хангах;

3.6.23. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлт хийх;

3.6.24. Эрүүл мэндийн байгууллагын орчинд гар угаах, халдваргүйжүүлэх болон ариун цэврийн өрөөний нөхцлийг бүрдүүлэх;

3.6.25. Эрүүл мэндийн ажилтанд анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх зорилгоор илрэх шинж тэмдэг, тохиолдлын тодорхойлолтыг хэвлүүлэн нүдэнд харагдахуйцаар байршуулах;

3.6.26. 1, 2-р хавьтлыг тусгаарлан ажиглах байрны бэлэн байдлыг хангах, хүн амын дунд халдвар тархсан нөхцөлд нэмэлт ор дэлгэх байгууллагын зохион байгуулалтад харьяа засаг захиргаа, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

3.6.27. Аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, БОЭТ, өрх, сум, тосгоны ЭМТ-үүд нь харьяа хүн амын дунд коронавируст халдвар (КОВИД-19) бүртгэгдсэн үед батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх, ойрын хавьтлыг тогтоож, тусгаарлан ажиглах, шинжилгээнд заасан хугацаанд хамруулах зэрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.7. Иргэний агаарын болон төмөр зам, нийтийн тээврийн газар:

3.7.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх;

3.7.2. Нисэх онгоцны буудал, авто, төмөр замын зорчигч үйлчилгээний төвүүдэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, галт тэрэг, агаарын хөлөгт тусгаарлах хэсгийг бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

3.7.3. Зорчигч тээврийн байгууллага аяллын явцад зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавьж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед холбогдох байгууллагад нэн даруй мэдээлж, зохих хариу арга хэмжээ авах;

3.7.4. Халдвар бүртгэгдсэн улс, орон нутаг руу аялал хийх тээврийн хэрэгслийн багийг хамгаалах хувцас, хэрэгсэл, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисоор хангах;

3.7.5. Ажилтанд урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дэглэм сахих талаар сургалт зохион байгуулж, амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодисоор тогтмол хангах;

3.7.6. Ариун цэврийн өрөө, гар угаах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээний танхим, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэгч бодисыг хүрэлцэхүйц тоо, хэмжээгээр байршуулах;

3.7.7. Мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг урсдаг цахим самбар болон бусад хэлбэрээр байршуулах, зорчигчдод халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх;

3.7.8. Үйлчлүүлэгчдийн биеийн халууныг зайнаас хэмжиж, амны хаалт зүүсэн зорчигчдод үйлчлэх;

3.8. Хилийн нэвтрэх цэг;

3.8.1. Хилийн нэвтрэх цэгт Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.8.2. Хилийн нэвтрэх цэгт сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн багаж, бодис, эмийн нөөцийг МХЕГ-ын даргын 2018 оны "Заавар батлах тухай" А/192 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан шаардлагын дагуу бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

3.8.3. Агаарын хилийн боомт дээр Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх APIS (Advance passenger information system) цахим программын тусламжаар зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, хариу арга хэмжээг төлөвлөх;

3.8.4. Онгоцны нисэх багийн даргаас зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, (general declaration form) галт тэрэг, вагоны дарга, үйлчлэгч, автобус, автомашины жолоочоос зорчигчийн эрүүл мэндийн мэдээлэл, зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтын хамт авч, хяналт тандалт хийх төлөвлөлтийг зохион байгуулах;

3.8.5. Улсын хилийн боомтоор нэвтэрч буй зорчигч, жолооч, нислэгийн баг бүрэлдэхүүн, галт тэрэг, вагоны дарга, үйлчлэгч, төмөр замын хөлөг ажилтнаас МХЕГ-ын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсаар асуумж судалгаа авч, биеийн халууныг хэмжин, хяналт тандалт хийх;

3.8.6. Зорчигч, жолооч бүрээс сүүлийн 72 цагийн дотор "SARS-CoV-2" вирус илрүүлэх бх-ПГУ шинжилгээнд хамрагдсан шинжилгээний дүнгийн хуудсыг шалгаж, "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг" хуудаст тэмдэглэгээ хийх;

3.8.7. Халдварын голомт бүхий бүс нутгаас ирсэн зорчигчийг Шадар сайдын 2020 оны 155 дугаар тушаалаар батлагдсан "Тусгаарлан ажиглалт болон гэрийн

ажиглалтыг зохицуулах түр журам"-ын 11.1-11.11 заалтын дагуу тээврийн хэрэгслээс буулгах эрэмбэлэн ангилалтыг хийж, тусгаарлан ажиглалтад шилжүүлэх;

3.8.8. Сэжигтэй тохиолдол илэрсэн үед түр тусгаарлаж, нийслэлд ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг, аймаг, орон нутагт эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

3.8.9. Сэжигтэй тохиолдлын мэдээг МХЕГ-ын даргын 2018 оны "Заавар батлах тухай" А/192 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар"-ын Схем 3-ийн дагуу шуурхай мэдээлэх;

3.8.10. Хавьтлыг бүртгэн тогтоож, түр тусгаарлан, биеийн халууныг давтан хэмжиж, нийслэлд ХӨСҮТ-ийн мэргэжлийн баг, аймаг, орон нутагт харьяа эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

3.8.11. Тээврийн хэрэгслийн бие бүрэлдэхүүн болон шаардлагатай тохиолдолд бусад зорчигчийн биеийн халууныг давтан хэмжиж, халуурах болон бусад шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн байгууллагад хандах талаар зөвлөгөө өгч, хилээр нэвтрүүлэх;

3.8.12. Галт тэргэнд сэжигтэй тохиолдол илэрвэл тухайн зорчигчийн суусан тасалгаа /купей/ болон нийтийн вагон, автобус, суудлын автомашины бүх зорчигчид, нисэх онгоцонд сэжигтэй зорчигчийн урд, ард, хажуу тус бүр 3 эгнээний хүмүүсийг "эрсдэл өндөртэй 1-р хавьтал" гэж үзэн амны хаалт зүүлгэж, түр тусгаарлах;

3.8.13. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлыг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлсэн тухай тэмдэглэл үйлдэж, мэдээллийг 2 цагийн дотор холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.8.14. Сэжигтэй зорчигч, хавьтагсдыг эмнэлгийн байгууллагад шилжүүлсний дараа тээврийн хэрэгсэл, түр тусгаарлах өрөө, ачаа, тээшинд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг ЗӨСҮТ, орон нутагт ЗӨСТ эсвэл зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хяналт тавих;

3.8.15. Халдварын сэжигтэй материалууд, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу устгуулах арга хэмжээ авах;

3.8.16. Тухайн халдварын талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллээр зорчигч, жолооч, онгоц, галт тэрэг, автомашины багийн бүрэлдэхүүн, хил, хяналтын болон бусад хамтран ажилладаг байгууллагыг тогтмол хангах;

3.8.17. Хил залгаа хөрш улсын боомтын хорио цээрийн байгууллагад өвчний талаарх мэдээллийг хүргүүлж, хамтарсан арга хэмжээг авах;

3.8.18. Монгол улсаас гарч буй зорчигчдоор эрүүл мэндийн мэдүүлэг бөглүүлэн, сүүлийн 72 цагт SARS-CoV-2 вирус илрүүлэх бх-ПГУ шинжилгээнд хамрагдсан шинжилгээний дүнгийн хуудсыг шалгаж, биеийн халууныг хэмжин, сэжигтэй тохиолдол илэрвэл буцаах арга хэмжээ авч, эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

3.8.19. Хэрэглэсэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл болон бусад хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын уутанд цуглуулж, зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад шилжүүлж, устгуулах;

3.8.20. Зорчигчдод эрүүл мэндийн хяналт хийсэн, эрэмбэлэн ангилж тусгаарлалтад шилжүүлэх үйл ажиллагаанд оролцсон хилийн хяналтын болон цагдаа, тагнуул, аюулгүй байдал, онцгой байдал зэрэг албадын хүн нэг бүрийн

мэдээллийг бүртгэж, тандалт хийн, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.8.21. Тухайн нөхцөл байдал нь гаалийн хяналтын бүс, талбай (терминал)-д үүсвэл энэхүү зааврын дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Дөрөв. Автовокзал, галт тэрэгний буудал, нисэх буудал, автозамын хяналтын постоор иргэдийг нэвтрүүлэх

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19) бүртгэгдээгүй орон нутгаас голомтот бүс нутагт ирж буй зорчигчийг нэвтрүүлэхдээ дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19) бүртгэгдээгүй орон нутгаас голомтот бүс нутагт ирж буй зорчигчийг нэвтрүүлэхдээ зорчигчийн овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, очих газрын хаяг, холбоо барих утас зэргийг асуумжаар авах;

4.1.2. Зорчигчийн халууныг зайнаас хэмжиж, эрүүл мэндийн байдалд тухайн цэгт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан хяналт тавих;

4.2. Коронавируст халдвар (КОВИД-19) бүртгэгдсэн голомтот бүс нутгаас халдвар бүртгэгдээгүй орон нутагт зорчих албан ажилтан болон иргэнийг нэвтрүүлэхэд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Тухайн цэгт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан зорчигчийн биеийн халууныг зайнаас хэмжиж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэгтэй эсэхэд хяналт тавих;

4.2.2. Халуурсан, сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон эмнэлзүйн шинж тэмдэг илэрч буй зорчигчийг харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдээлж, шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.2.3. 72 цагийн өмнө SARS-CoV-2 илрүүлэх бх-ПГУ шинжилгээний дүнгээр сөрөг гарсан иргэнийг нэвтрүүлэх;

4.2.4. Нэн шаардлагатай тохиолдолд нэвтрэх цэг дээр SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар шинжлэхэд сөрөг гарсан, коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илрээгүй зорчигчийг нэвтрүүлэх;

4.2.5. Албан томилолтоор ажиллахаар ирж буй ажилтанг 72 цагийн өмнө бх-ПГУ-ын шинжилгээнд хамрагдсан бол шууд нэвтрүүлэх арга хэмжээ авах;

4.3. Гадаад улс оронд зорчих болон ирэх иргэнийг нэвтрүүлэхдээ:

4.3.1. Гадаад улс оронд зорчих иргэнийг тухайн орны визийн шаардлагын дагуу шинжилгээнд хамрагдсан эсэх, эрүүл мэндийн байдалд хяналт тавьж нэвтрүүлэх;

4.3.2. Гадаад улс орноос ирж буй зорчигчийг 72 цагийн өмнө бх-ПГУ-ын шинжилгээнд хамрагдсан эсэх болон эрүүл мэндийн байдал хяналт тавьж нэвтрүүлэх.

Тав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтот бүс нутгаас ирсэн иргэн, албан үүрэг гүйцэтгэсэн ажилтанг тусгаарлан ажиглах

5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтот бүс нутгаас халдвар бүртгэгдээгүй орон нутагт очсон иргэнийг гэрийн ажиглалтад 14 хоногийн хугацаанд байлгаж, харьяа ерх, сум, тосгоны Эрүүл мэндийн төв хяналт тавих;

5.2. Тухайн иргэний гэр бүлийн бусад гишүүдийг ажиглалт, тусгаарлалтад хамруулах шаардлагагүй;

5.3. Голомтот бүс нутагт албан томилолтоор ажилласан ажилтан нь халдварын голомтод үүрэг гүйцэтгэсэн бол ирсэн даруйд бх-ПГУ-ын шинжилгээнд хамруулж, 7 хоногийн хугацаанд ажиглах байранд тусгаарлан хянах ба 7 дахь хоногт хийсэн бх-ПГУ-ын шинжилгээгээр сөрөг, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй бол дараагийн 7 хоногийн тусгаарлалтыг гэрийн ажиглалтад шилжүүлэх;

5.4. Голомтот бүс нутагт албан томилолтоор ажилласан ажилтан нь халдварын голомтод үүрэг гүйцэтгээгүй бол ирсэн даруйд бх-ПГУ-нд хамруулж, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй бол 7 хоногийн хугацаанд гэрт ажиглалтад байлгах.

5.5. Голомтод бүсээс ирж байгаа гадаадын болон дотоодын иргэдийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан гэрчилгээг үндэслэн 7 хоног тусгаарлан ажиглах байранд тусгаарлана.

5.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын илрүүлэг бх-ПГУ шинжилгээг эхний болон 6 дахь хоногт нь хамруулж халдвар илрээгүй тохилдлолд ажиглалтаас гаргана.

Зургаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг бүртгэх, мэдээлэх

6.1. Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөнд илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгүүд нь коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг үнэлэх;

6.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн эрүүл мэндийн ажилтан нь өвчтөнг тусгаарлаж, эрүүл мэндийн байгууллагын удирдлагад мэдээлэх;

6.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн бүх байгууллагад сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай тусгаарлаж, Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн 100 тоот утас болон Нийслэлийн эрүүл мэндийн газар (НЭМГ)-т мэдээлэх;

6.4. Орон нутагт сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай тусгаарлаж, аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд мэдээлэх;

6.5. Аймаг, нийслэлийн ЭМГ нь сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж (ШУН)-д 8008-6829 дугаарын утсаар 7/24 цаг болон eor@ncsd.gov.mn цахим хаягаар 2 цагийн дотор мэдээлэх;

6.6. ХӨСҮТ-ийн ШУН мэдээллийг хүлээн авч, анхны мэдээллийг ЭМЯ-нд 51-261629, хариуцлагатай жижүүрийн 31-323002 утас болон vochealth2014@gmail.com хаягаар тус тус мэдээлэх;

6.7. Мэдээллийн дагуу орон нутагт аймгийн ЭМГ болон нэгдсэн эмнэлэг, БОЭТ, сум, тосгоны ЭМТ, нийслэлд ХӨСҮТ, ЗӨСҮТ, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний баг ажиллан, тэнцэлт судалгаа хийж, сорьц авах;

6.8. Шуурхай хариу арга хэмжэвний баг нь сэжигтэй тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судлалын судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан 1,2-р хавьтлыг тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.9. Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээс хойш сэжигтэй, батлагдсан тохиолдол болон 1,2-р хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн лайнлистэд шивж оруулан, ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн хаягаар 24-48 цагийн дотор хүргүүлэх;

6.10. ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж нь дээрх мэдээллийг нэгтгэн, Эрүүл мэндийн яамны eochealth2014@gmail.com цахим хаягаар хүргүүлэх;

6.11. ЭМЯ-наас Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын онцгой комисс, Цагдаагийн ерөнхий газар, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар зэрэг холбогдох байгууллагуудад өдөр бүр нөхцөл байдлын мэдээг цахимаар хүргүүлэх;

6.12. ХӨСҮТ нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын мэдээллийг 24 цагийн дотор ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсэд хүргүүлэх;

6.13. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон Олон улсын өвчний ангилал-10-т (U.071-U07.2, Z03.8-) заасны дагуу халдварт өвчнийг мэдээлэх журмын дагуу Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвд мэдээлэх.

Долоо. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт судалгаа хийх

7.1. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага Коронавируст халдвар (КОВИД-19)-ын идэвхтэй тандалт судалгааг зохион байгуулна (Хүснэгт). Эрүүл мэндийн байгууллага өөрсдийн хүчин чадалд суурилан идэвхтэй тандалт судалгааг зохион байгуулах удирдамжийг боловсруулж хэрэгжүүлнэ.

7.2. Тандалт судалгааг дараах чиглэлээр зохион байгуулна. Үүнд:

7.1.1 Идэвхгүй тандалт - 119 дугаарт ирж байгаа дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүн амын дундах хандлага, ойлголтыг тандан судлана.

7.1.2. Идэвхтэй тандалт

7.1.2.1. Өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдыг тодорхой давтамжтайгаар лабораторид суурилсан тандалтад хамруулна.

7.1.2.2. Дайчлагдан ажиллаж буй төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчдыг тодорхой давтамжтайгаар лабораторид суурилсан тандалтад хамруулна.

7.1.3. Өргөжүүлсэн тандалт- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтыг хүн амын дунд өргөн хүрээнд (өрхөд суурилсан, эрсдэлтэй хүнд чиглэсэн) хийж шинэ өвчлөл, голомтыг илрүүлэх, эсхүл ийлдэс судлалын шинжилгээгээр хүн амын дундах коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтооно.

7.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт судалгааг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

7.2.1 Тохиолдолд суурилсан тандалт: Энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтын 2.8-т заасан тохиолдлын тодорхойлолтод тохирсон хүнийг эрүүл мэндийн

байгууллагууд батлагдсан журам, зааврын дагуу мэдээлнэ. Тухайн батлагдсан болон магадлалтай тохиолдлын 1,2-р хавьтлыг илрүүлэн тандана.

7.2.2 Томуу, томуу төст өвчний харуулдан тандалт: Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтыг өргөжүүлэх түр заавар"-ын дагуу гүйцэтгэнэ.

7.2.3 Эмнэлэгт суурилсан тандалт: Төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжиж, асуумж судалгаанд хамруулна. Яаралтай тусламжийн тасгаар ирсэн өвчтөнд хурдавчилсан оношлуураар SARS-CoV-2 антиген илрүүлэх шинжилгээ хийх ба бх-ПГУ шинжилгээ хийнэ. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх цаг авсан эсхүл төлөвлөгөөт эмчилгээ, үйлчилгээ хийлгэх өвчтөнийг харьяа нутаг, дэвсгэрийн хурдавчилсан оношилгооны цэгт хандаж 72 цагийн өмнө бх-ПГУ шинжилгээнд хамрагдсан байхыг шаардана. Эрүүл мэндийн ажилтнуудын халдвар авах эрсдэлээс хамаарч, тодорхой давтамжтайгаар лабораторийн шинжилгээнд хамруулна.

7.2.4 Сайн дурын шинжилгээ: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамрагдах хүсэлтэй иргэнийг хурдавчилсан оношилгооны цэгээр дамжуулан сорьцыг цуглуулж, лабораторийн шинжилгээнд хамруулна.

7.3. Лабораторийн шинжилгээ хийх, үр дүнг мэдээлэх

7.3.1. Идэвхтэй тандалтын чиглэл, хэлбэрээс хамаарч үндэсний түвшинд ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ийн Вирус судлалын лабораторит шинжилгээг хийнэ. Нийслэлийн хурдавчилсан оношилгооны цэг болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг хариуцан ажиллаж байгаа хөдөлгөөнт оношилгооны цэгээр дамжуулан цуглуулсан сорьцыг лабораторийн ачааллаас хамаарч ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ийн лабораторит тухайн үед хуваарилалт хийн шинжилгээнд хамруулна.

7.3.2. Аймаг, Нийслэлийн түвшинд молекул биологийн лабораторитой эрүүл мэндийн байгууллага өөрийн харьяалах нутаг, дэвсгэрийн хүрээнд лабораторийн шинжилгээ хийнэ.

7.3.4. Лабораторийн шинжилгээний тоон үзүүлэлтийн мэдээг ЭМЯ-наас санал болгож буй цахим системд тухай бүр оруулна. Тоон мэдээний дүн шинжилгээг НЭМҮТ нэгтгэн холбогдох байгууллагыг эргэн мэдээллээр хангаж ажиллана.

Хүснэгт. Тандалтын хэлбэр, хариуцах байгууллагын ерөнхий хуваарь

Тандалтын чиглэл, хэлбэр	ХӨСҮТ	ЗӨСҮТ	НЗМУТ	Бх-ПГУ шинжилгээ хийх лабораторитой бусад эрүүл мэндийн байгууллага*
1. Эрүүл мэндийн байгууллага, тусгаарлан ажиглах байр				
Батлагдсан тохиолдол, хавьтлын тандалт, хяналт, шинжилгээ	x			x
Гадаад улс орноос татан авалт (тусгай үүргийн онгоц, автомашин, галт тэрэг)- аар ирсэн иргэдийн хяналт	x			x
Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтан	x			x
Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төвийн яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж байгаа өвчтөн	x			
Эрчимт эмчилгээ, хүлээн авах, уушгины тасалт ажилладаг эрүүл мэндийн ажилтан, шүдний эмчилгээ, бронх дурандах, ходоод дурандах зэрэг аэрозол үүсгэх ажилбар хийдэг эрүүл мэндийн ажилтан		x		x
Эмнэлэгт (дээрх заалтаас бусад эрүүл мэндийн ажилтан) суурилсан тандалт			x	x
Томуу, томуу төст өвчний тандалт (эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тандалт)	x			x
2. Өндөр эрсдэлтэй байгууллага				
Өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан идэвхтэй тандалт			x	x
Дайчлөгдөн ажиллаж буй зорилтот бүлэг (төрийн тусгай албан хаагч, бусад)-т чиглэсэн тандалт		x		x
3. Бусад				
Өргөжүүлсэн тандалт	x	x	x	x
Сайн дурын шинжилгээ	x	x	x	x

Жич: * - томуугийн харуулдан тандалтын нэгж болон шинээр байгуулах бх-ПГУ
шинжилгээний лабораторийг оруулан тооцсон болно.

2021 оны 09 сарын 29 өдрийн тушварын
хоёрдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Хариу арга хэмжээний зохион байгуулалт

1.1. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дараах багуудыг зохион байгуулж ажиллана.

1.1.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 1 баг;

1.1.2. Аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг эсвэл бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хамтарсан 2-оос доошгүй баг;

1.1.3. Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвд 2-оос доошгүй баг; дүүрэг бүрт нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн хамтарсан 3-аас доошгүй баг;

1.1.4. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт тус бүр 2-оос доошгүй баг;

1.1.5. ХӨСҮТ-д шуурхай хариу арга хэмжээний 10 баг;

1.1.6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад хүний нөөц, хүчин чадлаас хамаарч 2-оос доошгүй баг;

1.2. Шуурхай хариу арга хэмжээний багт ажиллах эрүүл мэндийн ажилтныг сонгохдоо эрүүл мэнд, хүндэтгэн үзэх шалтгаантай (гэр бүлийн гишүүдийн аль нэг нь байнгын асаргаанд байдаг, өрх толгойлсон эцэг, эх гэх мэт) эсэх талаарх нарийвчилсан судалгаанд үндэслэнэ.

1.3. Баг, багийн гишүүдийн ажил, үүрэг, ажиллах хуваарийг тодорхойлон гишүүн бүрт танилцуулж, гарын үсэг зуруулна.

1.4. Багийн гишүүдийг халдварын сэргийлэлт, хяналт, тандалт, оношилгоо, эмчилгээний талаарх сургалтад тасралтгүй хамруулна.

1.5. Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр болон орлон ажиллах ажилтнуудыг сургаж, дадлагажуулна.

Хоёр. Шуурхай хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Шуурхай хариу арга хэмжээний баг нь сэжигтэй тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судлалын судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан, хавьтлыг тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Шуурхай хариу арга хэмжээний баг нь багийн ахлагч, тархвар судлагч эмч, эмнэлэггүй эмч, лабораторийн эмч эсвэл сувилагч, ариутгагч, жолооч нарын бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Багийн гишүүд хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн, зөв өмсч, тайлсан эсэх, байр, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын устгалын явцыг хяналтын хуудсаар хянана.

2.4. Багийн гишүүдийн биеийн халууныг өдөрт 2 удаа үзэж, тэмдэглэл хөтөлнө.

2.5. Багийн гишүүд дараах үүргийг гүйцэтгэнэ.

2.5.1. Багийн ахлагчийн үүрэг

2.5.1.1. Багийн гишүүдийн хамгаалах хувцас, хэрэгсэл, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ажлын болон амралтын цагийг зохицуулах, үйл ажиллагааг бусад багтай нийцүүлж, хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох ажлыг хариуцан, багийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангана.

2.5.1.2. Сэжигтэй тохиолдлын дуудлагыг хүлээн авмагц багийн гишүүдийг ажлын өдөр 30 минут, амралтын өдөр 1 цагийн дотор бүрдүүлж, бэлэн байдлыг ханган, хариу арга хэмжээг эхлүүлнэ.

2.5.1.3. Шууд удирдах албан тушаалтныг нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаарх мэдээллээр хангаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт баг ажиллуулах талаар хүсэлт тавьж, шийдвэрлүүлнэ.

2.5.1.4. Өвчтөн, түүний хавьтлыг эрсдлээр нь ангилж тусгаарласан тухай мэдээллийг аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн холбогдох мэргэжилтэнд мэдээлнэ.

2.5.1.5. Багийн хариу арга хэмжээний илтгэх хуудсыг бичиж, сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын тархвар судалгааны хуудас, лабораторийн шинжилгээний дүн зэргийг бүрэн бөглөсөн эсэхийг хянаж, шууд удирдах албан тушаалтанд хүргүүлнэ.

2.5.1.6. Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээс хойш сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн өвчтөний жагсаалтад шивж оруулан ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн eor@ncod.gov.mn хаягаар 24-48 цагийн дотор хүргүүлнэ.

2.5.2. Тархвар судлагчийн үүрэг

2.5.2.1. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол болон 1-р хавьтлаас тархвар судлалын асуумжаар судалгаа авч, тандалт хийн, эмнэлзүйч эмч, багийн ахлагчтай зөвлөлдөн, ажиглах, тусгаарлах эсэхийг шийдвэрлэнэ.

2.5.2.2. Хавьтлыг өртөх эрсдэлээр нь ангилж, 14 хоногийн хугацаанд тусгаарлах байр эсхүл гэрт нь тусгаарлаж, харьяалах сум, өрхийн эмчийн хяналтад шилжүүлнэ.

2.5.2.3. Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн ажилтанд мэргэжил, аргазүйн зөвлөмж, өвчтөн болон хавьталд зөвлөгөө өгнө.

2.5.2.4. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлын биеийн байдал хөнгөн, дунд бол дотуур утас, гар утас, камер, дуудлагын систем зэргийг ашиглан асуумж авна. Хэрэв өвчтний биеийн байдал хүнд эсвэл нас барсан бол гэр бүл, асран хамгаалагч, ойр дотны хүнээс асуумж авна.

2.5.2.5. Сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн өвчтөний жагсаалтад шивж оруулан багийн ахлагчид цахимаар хүргүүлнэ.

2.5.2.6. Сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын тархвар судалгааны хуудас, лабораторийн шинжилгээний дүн зэргийг бүрэн бөглөж, тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудасны хамт багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

2.5.2.7. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.

2.5.2.8. Батлагдсан тохиолдлыг эмчилж байгаа эмч нь өвчтнөөс тархвар судлалын судалгааны хуудсаар давтан асуумж, судалгаа авч, хариу арга хэмжээний багийн тархвар судлагч эмчид хүлээлгэн өгнө.

2.5.3. Эмнэлзүйч эмчийн үүрэг

2.5.3.1. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол, хавьталд үзлэг хийж, эрэмбэлэн ангилалт хийнэ.

2.5.3.2. Тархвар судлагч эмч, багийн ахлагчтай зөвлөлдөн тусгаарлах эсэхийг шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлнэ.

2.5.3.3. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлыг харьяалах эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, хүлээлгэж өгнө.

2.5.4. Лабораторийн эмч, сувилагчийн үүрэг

2.5.4.1. Сэжигтэй, магадлалтай тохиолдлоос сорьц авч, холбогдох журмын дагуу хадгалж, тээвэрлэн ХӨСҮТ эсвэл харьяалах вирус судлалын лабораторид хүргүүлнэ.

2.5.4.2. Сорьц илгээх тухай мэдээллийг лабораторийн эрхлэгч, ажилтанд урьдчилан мэдэгдэнэ.

2.5.4.3. Тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудсыг багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

2.5.5. Ариутгагчийн үүрэг

2.5.5.1. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг тархвар судлагч эмчийн хяналтан дор хийж, тэмдэглэл хөтөлнө.

2.5.5.2. Хариу арга хэмжээ авсны дараа тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийнэ.

2.5.5.3. Тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудсыг багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

2.5.6. Жолоочийн үүрэг

2.5.6.1. Машины бэлэн байдал, багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

2.5.6.2. Тархвар судлагч эмчийн хяналтан дор хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөж тайлна.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагад сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээ

3.1. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

3.2. Үзлэгийн явцад коронавируст халдвар (КОВИД-19) гэж сэжиглэсэн тохиолдолд эмч тухайн өрөө (гэр)-нөөс гарах, орох хөдөлгөөнийг хориглоно. Өрөө (гэр)-нд байгаа бүх хүнд амны хаалт зүүлгэж, сэжигтэй тохиолдлоос 2 метрээс дотогш зайд харьцахгүй байхыг анхааруулж, байгууллагын удирдлагад шууд мэдээлнэ.

3.3. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь мэдээг хүлээн авч, байгууллагын гарах, орох, хөдөлгөөнийг түр зогсооно. Сэжигтэй тохиолдолд үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлж байгаа иргэнийг бүртгэх, голомтыг халдваргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.4. Сэжигтэй өвчтнийг түр тусгаарлах өрөө эсвэл тасагт тусгаарлана.

3.5. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага шуурхай арга хэмжээний багийг дуудаж үүрэгжүүлнэ.

3.6. Шуурхай хариу арга хэмжээний баг нь сэжигтэй тохиолдлоос сорьц авч, хавьтлыг тогтоон, ялгаж голомтод халдваргүйжүүлэлт хийнэ.

3.7. Сэжигтэй тохиолдол илэрсэн тухай мэдээг "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр заавар"-т тусгасан бүртгэл, мэдээллийн дагуу мэдээлнэ.

Дөрөв. Хавьталд авах хариу арга хэмжээ

4.1. Батлагдсан тохиолдолд тархвар судалгаа хийж, хавьтлыг илрүүлж, хяналтад авна.

4.2. Хавьтлыг өртөх эрсдэлээр нь ангилж, 14 хоногийн хугацаанд эрүүл мэндийн байдлыг хянана.

4.2.1. Эрсдэл өндөртэй 1-р хавьтал бол тусгаарлан ажиглах байранд 7 хоног хянах ба 2 удаа бх-ПГУ шинжилгээнд хамруулна. Лабораторийн шинжилгээний хариу сөрөг бол сүүлийн 7 хоногийг гэрийн ажиглалтад шилжүүлнэ.

4.2.2. Эрсдэл багатай 1-р хавьтал бол гэрт нь тусгаарлаж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хяналтад байлгана. Шаардлагатай бол лабораторийн шинжилгээнд хамруулна.

4.3. Батлагдсан тохиолдлын хоёрдугаар хавьтлыг судалж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд бүртгэж, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.

4.4. 1-р хавьтлыг батлагдсан тохиолдолтой хамгийн сүүлд хавьтал болсноос хойш 14 хоногийн турш тусгаарлан эмчийн хяналтад ажиглана.

4.5. Эрсдэл өндөртэй 1-р хавьтлыг өрх, сум, тосгоны эмчийн хяналтад гэрийн нөхцөлд тусгаарлах бол дараах нөхцлийг харгалзан үзнэ.

4.6. Гэр бүлийн бусад гишүүдээс тусдаа нэг өрөөнд өөрийгөө тусгаарлах боломжтой байх;

4.6.1. Цөөн ам бүлтэй байх;

4.6.2. Нийтийн байр, оюутны байранд амьдардаггүй байх;

4.6.3. Гэр бүлийн гишүүд дотор ахмад настай, архаг суурь өвчтэй, нярай, бага насны хүүхэд байхгүй байх;

4.7. Хяналтын хугацаанд гэрээсээ гарахгүй, зочин урихгүй, олон хүнтэй уулзахгүй байхыг анхааруулна.

4.8. 1-р хавьталд эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж, биеийн халууныг өдөрт 2 удаа үзэж, тэмдэглэл хөтөлнө.

4.9. Хавьталд эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад утсаар яаралтай мэдэгдэнэ.

4.10. Тусгаарлалтын хугацаанд өрөө хооронд шилжүүлэх, өрөөнд шинээр хүн нэмж оруулахыг хатуу хориглоно.

4.11. Хавьталд коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжиглэж болох эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бх-ПГУ-ын шинжилгээнд яаралтай хамруулна.

4.12. Эрсдэл өндөртэй 1-р хавьтлыг тусгаарлагдсан даруйд, тусгаарлагдсанаас хойш 6-7 дахь хоногт ПГУ-ын шинжилгээнд хамруулна.

4.13. Тусгаарлалтын хугацаанд авсан 2 удаагийн ПГУ-ын шинжилгээгээр сөрөг илэрсэн, эмчийн үзлэгээр зовуурь, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй хавьтлыг тусгаарлалтаас гаргана.

4.14. Нэг өрөөнд тусгаарлагдаж байсан хүнээс коронавируст халдвар (КОВИД-19) илэрсэн тохиолдолд тухайн өрөөнд хамт байсан хүнийг халдвар илэрсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд үргэлжлүүлэн тусгаарлаж хянана.

4.15. Хавьтлын гэр бүлийн гишүүд эсвэл нийтийн болон дотуур байрны нэг өрөө, цэргийн хуаран, анги танхим, ажлын байр зэрэгт хамт байсан, тасаг, палатанд эмчлүүлсэн иргэдийг хавьтлын эхний шинжилгээний хариу гартал тухайн газар нь тусгаарлаж, ажил, хичээлээс түр чөлөөлнө.

4.16. Хавьтлын шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд түр тусгаарлалтыг цуцлах ба эерэг бол дахин тархвар судалгаа хийнэ.

4.17. Батлагдсан тохиолдлын хавьтал болох нярай болон бага насны хүүхэд нь бх-ПГУ-ийн шинжилгээгээр сөрөг бол гэр бүл болон хууль ёсны асран хамгаалагчийн хараа хяналтад үлдэнэ.

4.18. Батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх тасагт асран хамгаалагчийг дагаж бага насны хүүхдийг ирүүлэхгүй байх асуудлыг тухайн орон нутаг шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 07 сарын 18 өдрийн 4 тушаалын
гурвадугаар хавсралт 29

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД МӨРДӨХ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн бус байгууллагын барилга байгууламжийг ашиглан эмнэлэг дэлгэж, коронавируст халдварын тохиолдлыг тусгаарлах, тусгаарлан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, илрүүлэг, эрэмбэлэн ангилалт хийх үйл ажиллагаанд энэхүү зааврыг баримтлана.

1.2. Эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр хэрэгжиж буй халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлын менежментийн журам, зааврыг мөрдөж ажиллана.

1.3. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүн бүрийг эрсдэлтэйд тооцон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй бүх ажиллагсад тусламж үйлчилгээний төрөл, хэлбэрээс үл хамааран амны хаалт, нүүрний хаалт, эмнэлгийн нэг удаагийн халадыг тогтмол хэрэглэж, гарын эрүүл ахуйг сахиж халдвараас сэргийлэх стандарт даглэмийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Тусгаарлах эмнэлгийн зохион байгуулалт

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлыг эмнэлэгт, хавьтлыг халдварт өртөх эрсдэлээр ангилан тусгаарлан ажиглах байр эсхүл гэрт нь тусгаарлана.

2.2. Нийтийг хамарсан халдвар бүртгэгдэж орны ачаалал ихэсч, тусгаарлах эмнэлэг, хүрэлцээгүй болсон үед нэмэлтээр эмнэлэг дэлгэх, шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрээр өвчилсөн иргэдийг тусгаарлан ажиглах байранд, хавьтлыг гэрт нь тусгаарлах арга хэмжээг нөхцөл байдалд тохируулан авч хэрэгжүүлнэ.

2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг тусгаарлах эмнэлэг, байгууламж нь халдвартай буюу улаан, халдварын эрсдэл дунд буюу шар, халдваргүй (ногоон) гэсэн 3 бүсээр хувааж, тусгаарлалтыг зохион байгуулна. Доорх бүсүүд нь хоорондоо бүрэн тусгаарлагдсан байна.

2.3.1. Халдвартай улаан бүсэд халдварын сэжигтэй, магадлалтай, батлагдсан үйлчлүүлэгчийн хэвтэн эмчлүүлэх хэсэг;

2.3.2. Шар бүсэд халдвартай бүсэд ажилласан эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас тайлах хэсэг байна. Тус хэсэгт 50 литрээс дээш хэмжээтэй (өргөн 50 см, урт нь 80 см дээш байх) хог хаягдал цуглуулах уут бүхий хогийн сав, гар халдваргүйжүүлэх бодис, гутал халдваргүйжүүлэх уусмал болон урт бариултай губка, нүдний шил халдваргүйжүүлэх бодис зэргийг бэлтгэсэн байна.

2.3.3. Халдваргүй ногоон бүсэд эмнэлгийн ажилтны байрлах өрөө, эмнэлгийн бусад хэсгийг хамруулна.

2.4. Тусгаарлах эмнэлэгт өвчтөн хүлээн авах хаалга, эмнэлгийн ажилтны орх, гарах хаалга тусдаа байхаар зохион байгуулна. Тусгаарлах эмнэлгийн өвчтөний өрөө нь агааржуулалт сайтай байх ба механик агааржуулалттай, байгалийн агааржуулалттай бол салхивч нь нээгддэг байна.

2.5. Сэжигтэй тохиолдлыг шинжилгээний хариу гартал нэг, нэгээр тусгаарлана. Хэрэв 1-ээс дээш хүнийг 1 өрөөнд тусгаарлах бол ор хоорондын зай нэг метрээс дээш байх ба ор хооронд тусгаарлагч ашиглана.

2.6. Батлагдсан тохиолдлыг нэг оронд оногдох талбайн хэмжээ 8 м²-аас багагүй байхаар тооцож хамтад нь тусгаарлаж болно.

2.7. Шинээр оношлогдсон өвчтөнийг эмчилгээ, тусгаарлалтын хугацаа дуусч байгаа хүнтэй хамт нэг өрөөнд тусгаарлахгүй.

2.8. Тусгаарлах өрөө нь дотроо гарын угаалтуур, суултууртай байна. Өрөө нь дотроо ариун цэврийн өрөөгүй нийтийн ариун цэврийн өрөө ашиглаж байгаа үед коридорыг улаан бүсэд тооцож зохион байгуулалтыг хийнэ.

2.9. Хөдөө, орон нутагт биосуултуур, гоожуурт угаагуур, жорлон ашиглаж болно. Бусад үйлчлүүлэгч, амнэлгийн ажилтны ашиглаж байгаагаас тусдаа байна.

Гурав. Тусгаарлах эмнэлэгт мөрдөх халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.1. Халдвартай бүсэд мөрдөх халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.1.1. Ажилтан улаан бүсэд орох давтамж, ажиллах хугацааг бага байлгахаар тооцож, үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.2. Батлагдсан болон сэжигтэй тохиолдолд тусламж үзүүлэх ажилтныг тус тусад нь томилно. Хэрэв нэг ажилтан ажиллаж байгаа бол сэжигтэй тохиолдолд тусламж үйлчилгээг эхэлж үзүүлсэний дараа батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тохиолдол хооронд хамгаалах хувцас солино.

3.1.3. Үйлчлүүлэгчийн өрөөнд халдваргүйжүүлэлт хийхдээ өвчтөн болон орчны эд зүйлд хүрэлцэж хувцсаа бохирдуулахаас сэргийлж, зай барина.

3.1.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг Хүснэгт 2-т заасны дагуу зөв, зүй зохистой хэрэглэнэ.

3.1.5. Тусламж үйлчилгээ үзүүлэх үедээ өвчтөнд хүрэлцсэн бол гадна талын бээлийг үйлчлүүлэгч хооронд солино.

3.1.6. Халдвартай бүсэд байгаа мэдээллийг цахимаар авах боломж (дата, таблет, гар утас, бусад тоног төхөөрөмж)-оор хангана. Эрүүл мэндийн ажилтнууд халдвартай бүсэд өөрсдийн гар утсыг авч орж болохгүй.

3.1.7. Халдвар дамжуулах эрсдэл багатай даралтны аппарат, чагнуур, халууны шил, пульсоксиметр зэрэг багаж хэрэгслийг үйлчлүүлэгч хооронд 70 хувийн спирт эсвэл зориулалтын халдваргүйжүүлэх бодистой салфеткаар арчиж халдваргүйжүүлнэ.

3.1.8. Өвчтөний өрөөний агаар сэлгэлтийг 2 цаг тутам 10-15 минут хийж, өрөөний хаалгыг хаалттай байлгана.

3.1.9. Тусгаарлалтад байгаа үйлчлүүлэгчийг өрөөнөөс гарах, бусад хүмүүстэй уулзахыг хориглоно.

3.1.10. Тусгаарлалтад байгаа үйлчлүүлэгчийн эд зүйлсийг өрөөнөөс гаргахгүй. Зайлшгүй шаардлагатай хэрэгцээний эд зүйлсийг гаднаас оруулж болно.

3.1.11. Үйлчлүүлэгчийн өрөөнд орох эмнэлгийн ажилтан (инженер, техникийн ажилчин, сантехникийн слесарь), ар гэр, сахиур зэрэг хүний тоог хязгаарлаж, орж, гарсан хүмүүсийн бүртгэлийг хөтөлнө. Өвчтөний өрөөнд (улаан бүс) орсон ажиллагсадын бүртгэлийг хөтөлнө.

3.1.12. Тусгаарлах эмнэлэгт зөөврийн рентген, хэт авианы оношилгоо хийх аппарат, тоног төхөөрөмж байршуулсан байна.

3.2. Хувцас тайлах хэсэг буюу шар бүсэд мөрдөж ажиллах халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.2.1. Хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөхгүйгээр халдвартай болон завсрын бүсэд орохыг хатуу хориглоно.

3.2.2. Хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж гараа халдваргүйжүүлнэ.

3.2.3. Хувцас тайлах хэсгийг камержуулна.

3.2.4. Хувцас тайлах дараалал, бие бүрэн харагдах толь байршуулна.

3.2.5. Ажилтан хувцас тайлахдаа дараалал, санамжийг нэг бүрчлэн харж, толинд шалгаж тайлна.

3.2.6. Нэг удаагийн үзлэгийн бээлийг ажил дууссаны дараа халдваргүйжүүлэхгүй шууд тайлж, хаях бөгөөд зөвхөн ахуйн бээлийг халдваргүйжүүлнэ.

3.2.7. Халдвартай бүсэд өмссөн гутлаа шар бүсэд тайлж үлдээгээд ногоон бүс рүү цэвэр гутлыг өмсөж орно. Өмсөх гутлыг шар бүсийн гадна үүдэнд бэлтгэж тавьсан байна.

3.2.8. Хувцас тайлах хэсэгт гар халдваргүйжүүлэх бодис нь мэдрэгчтэй эсвэл тохойгоор ажилладаг савтай байна.

3.2.9. Хувцас тайлах хэсэгт үлдээх эсвэл үйлчлэгч цэвэрлэж, халдваргүйжүүлээд ногоон бүс рүү гаргана.

3.2.10. Шар бүс дэх хог хаягдлыг ариутгалын ажилтан эсвэл үйлчлэгч улаан бүсээр гаргаж, шар бүсэд халдваргүйжүүлэлтийг хийгээд хамгаалах хувцсаа тайлна.

3.2.11. Шар бүсэд цэвэрлэгээний ус, халдваргүйжүүлэх уусмалыг зайлуулах бохир усны шугам хоолой байхгүй үед улаан бүс рүү оруулж асгана.

3.3. Халдваргүй бүсэд мөрдөж ажиллах халдвараас сэргийлэх арга хэмжээ

3.3.1. Эмнэлгийн ажиллагсadyг аль болох нэг нэгээр байлгана. Өрөө нь агааржуулалт хийх боломжтой байна.

3.3.2. Өрөө хооронд сэлгүүцэхгүй, хамт сууж хоол идэхгүй, аяга, тавга зэрэг хоолны хэрэгсэл тусдаа байна.

3.3.3. Өвчний түүх, сувилгааны карт зэрэг цаасан материалтай харьцахдаа нэг удаагийн амны хаалт зүүж, ажил дууссаны дараа гараа угаах эсвэл халдваргүйжүүлнэ.

3.3.4. Цаасан материалыг халдваргүй бүсэд сувилагчийн постон дээр хөтөлнө. Амрах өрөөнд оруулж хөтлөхийг хориглоно.

3.3.5. Халдвартай бүсэд хэрэглэсэн эд зүйл, цаасан материалыг халдваргүй бүсэд оруулахыг хориглоно.

3.3.6. Эмнэлгийн ажиллагсadyн байрлах хэсэгт усанд орох болон хувцас угаах, индүүдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.3.7. Ус буцалгагч, хоол халаах цахилгаан зуух, хөргөгчтэй байна.

3.3.8. Эмнэлгийн өмд, цамц, гутал 2-оос доошгүй байх, хамгаалах хувцасны дотор өмссөн өмд цамцыг халдваргүй бүсэд ороод сольж өмсөх өмд, цамц, гутал тусдаа байна.

3.3.9. Багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгахад Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг мөрдөж ажиллана.

Дөрөв.Аэрозол үүсгэх ажилбарын үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд дараах ажилбаруудыг хийх үед аэрозол хэлбэрээр халдвар дамжих эрсдэлтэй.

4.1.2. Бронх дурандах;

4.1.2. Интубаци тавих, авах;

4.1.3 Амьсгал, зүрхний сэхээн амьдруулах тусламж үзүүлэх (CPR);

4.1.4. Зохиомол амьсгал (маск, интубаци);

4.1.5. Соруулга хийх;

4.1.6. Амьсгалын замд хийгдэх мэс засал;

4.1.7.Шүдний эмчилгээ, өрөм, борын машин ажиллуулан тусламж үзүүлэх

4.2. Аэрозол үүсгэх ажилбар хийх өрөө нь агаарын сөрөг даралттай эсвэл механик агааржуулах системтэй, салхивчаар агаар сэлгэлт хийх боломжтой байна. Хэрэв механик агааржуулах систем ашиглаж байгаа тохиолдолд агаар солилцох давтамж нь нэг цагт 12-оос багагүй байна.

4.3. Ажилбарын үед өрөөнд байх хүний тоог хамгийн бага хэмжээнд байлгана.

4.4. Ажилбар дууссаны дараа өрөөний агааржуулах системийг ажиллуулан агаар сэлгэлт хийж, өрөөг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

4.5. Аэрозол үүсгэх ажилбар гүйцэтгэх эрүүл мэндийн ажилтан дараах иж бүрэн хамгаалах хувцас, эмнэлгийн зориулалтын 95 хувь буюу түүнээс дээш шүүлтүүртэй (N95, FFP2, FFP3) амны хаалт хэрэглэнэ.

Тав. Өвчтөн шилжүүлэх, тээвэрлэх үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг өөр эмнэлэгт шилжүүлэх, зөөвөрлөх асуудлыг эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналтын баг зөвшилцөн шийдвэрлэнэ.

5.2. Зайлшгүй шаардлагатай оношилгоо, эмчилгээ хийх зорилгоор өвчтөнг эмнэлгийн бусад тасаг, хэсэг, өөр эмнэлэг рүү тээвэрлэх бол очих зам талбайг урьдчилан чөлөөлүүлж, бусад хүмүүстэй хавьтал болохоос сэргийлнэ.

5.3. Тээвэрлэх, зөөх үед үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэж, эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцас өмсөнө.

5.4. Автомашин ашиглан тээвэрлэх үед үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй бол эмч, эрүүл мэндийн ажилтан жолоочийн бүхээгт сууна.

5.5. Коронавируст халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг зөөх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

5.6. Жолооч, эмчийн урд кабин хэсэг, зорчигчийн хэсгээс бүрэн тусгаарлагдсан байна.

5.7. Тээвэрлэх явцад цонх нээж агаар сэлгэлт хийнэ. Машины агааржуулах төхөөрөмж (air condition)-ийг ажиллуулахгүй. Гаднах агаараас сэлгэх (дотор агаараар сэлгэлтийг хориглох) сорох, хүйтэнд пар асвах ба гадар агаараас сэлгэх горимоор ажиллуулна.

5.8. Түргэн тусламжийн машинд хүчилтөрөгчийн хангамж, маск, амбу, интубаци тавих хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, гар халдваргүйжүүлэгч, дамнуурга, хогийн сав, цэвэрлэгээний материал, халдваргүйжүүлэх бодис гэх мэт яаралтай тусламж үзүүлэх болон халдвараас сэргийлэх хэрэгслийг бэлэн байлгана.

5.9. Автомашины аюулгүй байдлыг хангах, хурд тохируулахын зэрэгцээ дотроос холбоо барих боломжтой харилцаа холбооны хэрэгсэл, гар утастай байна.

5.10. Автомашиныг ашигласан тохиолдол бүрт гар хүрэлцэх хэсгүүдийг арчиж халдваргүйжүүлнэ.

5.11. Бөөлжис, цэр, цус зэрэг биологийн шингэнээр бохирлогдсон бол халдваргүйтгэн цэвэрлэнэ.

5.12. Автомашины кабиныг цэвэрлэсний дараа гар хүрэлцдэг хэсгүүдийг арчиж, өвчтөн хүрэлцээгүй бусад хэсэгт мананцар үүсгэгч, шүршигч ашиглан халдваргүйжүүлнэ. Мананцар үүсгэгч ашиглаж байгаа үед хаалга, цонхыг хааж, дотор талд хүн байхгүй нөхцөлд хийнэ.

Зургаа. Коронавируст халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг зөвх тээвэрлэх үед өмсөх хамгаалах хувцас, хэрэгсэл

6.1. Автомашины бүхээгийн хэсэг бүрэн тусгаарлагдсан, өвчтөнийг суух, буух зэрэгт тусалцаа үзүүлэх шаардлагагүй, 1 метрээс дотогш зайд харьцахгүй үед жолооч нэг удаагийн амны хаалт, ажлын хувцасны гадуур халад эсвэл комбинзон, нүдний шил, нүүрний хаалтны аль нэгийг өмсөнө. Ажлын бээлий өмсч, ажил дууссаны дараа гараа угааж, халдваргүйжүүлэн бээлийг солино.

6.2. Автомашины бүхээгийн хэсэг тусгаарлагдаагүй, дамнуурга ашиглах, өвчтөнийг буух, суухад туслах зэргээр өвчтөнтэй 1 метрээс дотогш зайд харьцах эрсдэлтэй бол жолооч иж бүрэн хамгаалах хувцас өмсөнө.

6.3. Эмч тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг үзэх, суулгах, буулгах, эмнэлэгт хүлээлгэн өгөх зэрэг ойр зайд харьцах учраас иж бүрэн хамгаалах хувцас өмсөнө.

6.4. Өвчтөнийг хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлт цэвэрлэгээг хийнэ. Хүргэж ирсэн эмч, жолоочийн хамгаалах хувцас хэрэгслээ тайлах газрыг бэлтгэж, гар угаах, хувцас солих нөхцлийг бүрдүүлсэн байна.

Долоо. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх арга хэмжээ

7.1. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтан болон коронавируст халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа эрүүл мэндийн бус байгууллагын ажиллагсадыг халдварт өртөхөөс сэргийлэх арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлнэ.

7.2. Ажиллагсадыг халдварт өртөхөөс сэргийлэх, сургах, бэлтгэх, шаардлагатай хэрэгслээр хангахад байгууллагын удирдлага, санхүү, аж ахуй, эмнэлгийн тусламжийн чанар, халдварын сэргийлэлт хяналт, хүний нөөц, сувилахуй, дотоод хяналтын албад хамтран ажиллана.

7.3. Тусгаарлах эмнэлэг, ажиглалтын байр, илрүүлэг, эрэмбэлэн ангилалт хийх нэгжүүдэд ажиллах эрүүл мэндийн ажилтанг сургаж, бэлтгэсэн байна.

7.4. Тусгаарлах эмнэлэгт ажиллах буй эрүүл мэндийн ажилтан 14 хоногийн хугацаанд тусгаарлагдан ажиглагдах бөгөөд, батлагдсан тохиолдолд тусламж үзүүлсэн сүүлийн өдрөөс эхлэн 14 хоног ажиглалтад байна.

7.5. Тусгаарлагдан ажиллах ажиллагсад хувийн бэлтгэлийг хангаж, ариун цэврийн хэрэгслийг бэлтгэнэ.

7.6. Ажиллах хугацаанд амьдрах өрөө нь тав тухтай, усанд орох, гар угаах, хувцас угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.

7.7. Ар гэрийн нөхцөл байдал, эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж тусгаарлагдан ажиллах эрүүл мэндийн ажилтанг сонгоно.

7.8. Цусны даралт, зүрх судасны архаг өвчин, чихрийн шижин, хавдартай, амьсгалын замын архаг эмгэгтэй, жирэмсэн эрүүл мэндийн ажилтанг батлагдсан тохиолдолд тусламж үзүүлэхээр томилон ажиллуулахыг хориглоно.

7.9. Тусгаарлагдан ажиллах эрүүл мэндийн ажилтанг эрүүл мэндийн үзлэг (цээж гэрэлд харах), коронавирус илрүүлэх шинжилгээнд заавал хамруулна.

Найм. Эрүүл мэндийн байгууллагын чанар, халдварын сэргийлэлт, хяналт, сувилахуйн албаны гүйцэтгэх үүрэг

8.1. Хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуй сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх гэх мэт халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эрүүл мэндийн ажиллагсадыг тогтмол сургана.

8.2. Ажиллагсадыг тусгаарлалтад орохоос өмнө хамгаалах хувцас өмсөх, тайлах, гар угаах, халдваргүйжүүлэх дадлыг хүн тус бүрээр нэг бүрчлэн шалгана.

8.3. Зөв дадал эзэмшээгүй, сургалтад хамрагдаагүй ажилтанг халдварын голомтод оруулж ажиллуулахыг хатуу хориглоно.

8.4. Халдвараас сэргийлэх зааврыг хэрэгжүүлэн, мөрдөж ажиллах, хүн бүрийн хариуцлагын талаар ажиллагсадад анхааруулга өгч баримтжуулсан байна.

8.5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх багийн ахлагчийг томилно.

8.6. Батлагдсан тохиолдолд тусламж үзүүлж тусгаарлагдан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанг үзлэг, шинжилгээнд заавал хамруулах ба тархвар судлаач, хүний нөөцийн ажилтан хариуцан ажиллана (Хүснэгт 1).

8.7. Ажиллах болон ажиглалтын хугацаанд өдөр бүр шинж тэмдгийн тандалт хийж, биеийн халууныг өглөө, оройд 2 удаа үзнэ.

8.8. Тусгаарлагдан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсч, аюулгүй тайлж байгаа байдалд багийн ахлагч хяналт тавина. Эсвэл хяналт хийхээр томилогдсон ажилтан хяналт тавина.

8.9. Ажилтанд эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн бол ахлан ажиллаж байгаа эмч, тархвар судлаачид мэдэгдэж хугацаа харгалзахгүйгээр ПГУ-ын шинжилгээнд хамруулна. Ажлыг зогсоож, тусгаарлалтад шилжүүлнэ.

8.10. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад санамсаргүйгээр халдварт өртөх эрсдэл үүссэн тохиолдолд (хамгаалах хувцас өмсөөгүй, буруу өмссөн, хувцас урагдсан, гэмтсэн, биологийн шингэнд хамгаалалтгүй хүрсэн зэрэг) эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналт (ХСХ)-ын багт мэдэгдэнэ.

8.11. Халдварын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлоос тархварзүйн асуумж авах, хөнгөн үед биеийн байдлыг хянах үед тусгаарлах өрөөнд орохгүйгээр дотуур утас, гар утас, камер, дуудлагын систем ашиглаж, хавьтал болох, халдвартай бүсэд орох эрүүл мэндийн ажилтны тоо, давтамжийг багасгана.

8.12. Батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хавьтал болох хугацааг аль болох бага байлгана.

8.13. Тусгаарлалтын хэсэгт томилогдсон эрүүл мэндийн ажилтнаас бусад хүн орохыг хориглоно. Зайлшгүй шаардлагаар өрөөнд орсон эрүүл мэндийн ажилтан, ар гэрийн хүмүүсийн бүртгэлийг хөтөлнө. Хамгаалах хувцсыг өмсүүлнэ.

8.14. Хувцас өмсөх, тайлах, гарын эрүүл ахуй сахилт, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг шалгах хуудсаар өдөр бүр хянах, хянаж байгаа эсэхэд ХСХ, чанар, сувилахуйн алба хяналт тавьж ажиллана.

8.15. Амны хаалтыг 2 давхарлаж зүүхгүй байх, ялангуяа шүүлтүүртэй амны хаалтны дотор нэг удаагийн амны хаалт зүүхэд нүүрэнд бүрэн наалдаж битүүмжлэл үүсэхгүй гэдгийг ажиллагсдад ойлгуулна.

8.16. Батлагдсан тохиолдолтой шууд харьцсан, 1 метрээс дотогш зайд тусламж үзүүлсэн, эсвэл түүний орчинтой харьцсан, азрол үүсгэх ажилбар гүйцэтгэсэн эмнэлгийн ажилтанг хамгаалах хувцастай байсан эсэхээс үл хамаарч "эрсдэлд өртсөн" гэж үзнэ.

8.17. Эрсдэлд өртсөн ажилтан халдвар авах эсэх нь дараахь зүйлсээс хамаарна:

8.17.1. Хамгаалах хувцас хэрэгслийг зөв зохистой өмссөн байдал;

8.17.2. Хамгаалах хувцсыг тайлах явцад алдаа гаргаагүй байх;

8.17.3. Гарын ариун цэвэр сахих 5 заалтад гараа зөв угааж, халдваргүйжүүлсэн байх;

8.17.4. Эмнэлгийн орчин болон гар хүрэлцэх хэсгийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг өдөрт 3-аас доошгүй удаа хийж байсан эсэх.

Ес. Тусгаарлах эмнэлэгт хийгдэх цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт

9.1. Цэвэрлэгээ хийх ажилтанг өжиллах тасаг, нэгжид нь ажлын байрны сургалтанд хамруулж бэлтгэсэн байна.

9.2. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж байгаа үйл явцад баг ахлан ажиллаж байгаа эмч болон сувилагч хяналт тавьж зөвлөмж, заавар өгч ажиллана.

9.3. Өвчтөний өрөөнд өдөрт 1-2 удаа цэвэрлэгээ хийнэ. Гар их хүрэлцдэг, бохирдох эрсдэл ихтэй талбай, эд зүйлсийн гадаргууг өдөрт 3 удаа арчиж халдваргүйжүүлнэ.

9.4. Өвчтөн байгаа өрөөнд халдваргүйжүүлэх бодисыг цацаж, шүршиж хэрэглэхгүй, өрөөний хана, тааз зэрэг талбайг хамруулан халдваргүйжүүлэлт хийх шаардлагагүй.

9.5. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх дарааллыг тасаг тус бүр гаргаж, үйлчилгээний болон ариутгалын ажилтанд өгнө.

9.6. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхэд дараах зарчмыг баримтална.

9.7. Цэвэрлэгээ хийсний дараа халдваргүйжүүлэлт хийнэ.

9.8. Цэврээс бохир, дээрээс доош, гаднаас дотогш чиглэлээр хийнэ.

9.9. Чийгтэй цэвэрлэгээ хийнэ. Хог шүүрдэх, хуурай алчуураар тоос арчиж орчинд тоос босгохыг хориглоно.

9.10. Цэвэрлэгээний бодистой уусмал уруу халдваргүйжүүлэх бодисыг нэмж хольж хэрэглэхгүй.

9.11. Бүс тус бүрт ашиглах цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх хэрэгсэл тусдаа байна. Бүс хооронд дамжуулж хэрэглэхгүй.

9.12. Хэт өндөр түвшрүүлэг (концентраци)-тай бодисоор халдваргүйжүүлэлт хийхгүй.

9.13. Халдваргүйжүүлэх бодисын үйлчлэх хугацааг баримтлана.

9.14. Халдваргүйжүүлэлтийг арчиж хийнэ. Гар шүршигч ашиглаж байгаа үед зай талбай үлдээхгүй хэсэг хугацаанд чийгтэй байхаар тооцож хангалттай хэмжээгээр шүршээд алчуураар тарааж арчина.

Арав. Биологийн шингэнээр бохирлогдсон талбайг цэвэрлэж, халдваргүйжүүлэх дараалал

10.1. Цус, шээс зэргийг нэг удаагийн сальфетка ашиглан шингээж авна.

10.2. Бөөлжис, хоолны үлдэгдэл гэх мэт зүйлийг тосгуур ашиглан хамж авч халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.

10.3. Угаалгын нунтаг, саван бүхий цэвэрлэгээний бодистой уусмалаар бохирлогдсон талбайг арчиж цэвэрлэнэ.

10.4. Цэвэрлэсэн талбай хатсаны дараа халдваргүйжүүлэх уусмалд ногсоон нойтон алчуураар арчиж халдваргүйжүүлнэ.

10.5. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн алчуурыг халдвартай хог хаягдлын уутанд хийж хаяна.

10.6. Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зөвшөөрөлтэй бодисыг сонгож хэрэглэнэ. Түгээмэл хэрэглэдэг бодисыг дараах концентрацаар найруулж хэрэглэж болно. Үүнд: Гипохлорт натри 0.1%, 0.5%, жавелион 0.015%, 0.03%, хлорсепт 0.02-0.1% уусмал 10-20 минутад халдваргүйжүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

10.7. Мананцар үүсгэгч, автомаксыг голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхэд гар хүрэхгүй талбайг халдваргүйжүүлэхэд ашиглана. Өөрөө автоматаар унтардаг мананцар үүсгэгчийг шар бүсийн халдваргүйжүүлэлтэд хүнгүй үед ашиглаж болно.

10.8. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхэд хамгаалах хувцас өмсөнө. Ахуйн бээлийг ажил дууссаны дараа халдваргүйжүүлэх уусмалд дүрж халдваргүйжүүлээд тайлна.

Арван нэг.Цагаан хэрэгсэл, зөөлөн эдлэлийн угаалга, халдваргүйжүүлэлт:

11.1. Үйлчлүүлэгчийн хэрэглэсэн цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг цэвэрлэж, халдваргүйжүүлэхэд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан зааврыг баримтална.

11.2. Үйлчлүүлэгч гарсны дараа ор, матрас, хөнжил, гудас, дэр, цагаан хэрэгсэл зэрэг орны бүх хэрэгслийг угааж, халдваргүйжүүлнэ.

11.3. Ор, матрасны тоос, шороог арчиж цэвэрлээд, халдваргүйжүүлнэ.

11.4. Цагаан хэрэгсэл, гудас, матрасны гаднах углаа зэргийг угаагч бодистой 60-90°C хамийн халуун усаар автомат угаалгын машинд угааж индүүднэ.

11.5. Халуун ус хэрэглэх боломжгүй бол халдваргүйжүүлээд, угаагч бодис ашиглан угаана. Угаасны дараа цэвэр усаар зайлж, хатаагаад индүүднэ.

11.6. Цус, шээс зэрэг биологийн шингэнээр бохирлогдсон цагаан хэрэгслийн бохирдолтой хэсгийг цайруулагч, угаагч бодис ашиглан угаасны дараа халдваргүйжүүлэх уусмалд хийнэ.

11.7. Угаах боломжгүй гудас, матрас, хөнжил зэргийг дезкамераар халдваргүйжүүлнэ. Эсвэл хүйтний нөлөөг ашиглан гадаа тавина.

11.8. Цагаан хэрэгсэл, ор дэрний хэрэгслийн угаалга, халдваргүйжүүлэлтийг эмнэлгийн угаалгын газарт хийнэ.

11.9. Угаалгын газар уруу зөөх уут, сав, тэргэнцэртэй байна.

11.10. Бохир цагаан хэрэгсэлтэй харьцах ажилтан хамгаалах хувцас өмсөнө.

11.11. Үйлчлүүлэгч эмнэлгээс гарахад хувийн эд зүйлс, хувцас, гар, нүүрийн алчуур зэрэг зөөлөн эдлэлийг гэртээ угааж, халдваргүйжүүлэх, индүүдэх талаар зөвлөмж өгнө.

Арван хоёр. Хог хаягдлын менежмент

12.1. Хог хаягдлыг цуглуулах, зөөх, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалыг мөрдөнө.

12.2. Үйлчлүүлэгчийн өрөөнөөс гарч байгаа бүх хог хаягдлыг халдвартайд тооцож "Биоаюултай" таних тэмдэг бүхий шар өнгийн уутанд цуглуулна.

12.3. Хог хаягдлыг зөөх, тээвэрлэх зэрэг хүрч ажиллах ажилтан хамгаалах хувцас хэрэгсэл өмсөнө.

12.4. Хамгаалах хувцас хэрэгслийг тайлахад хогны уут дүүрсэн үед дээрээс нь чихэх, дарах үйлдлийг хийхгүй.

12.5. Хог хаягдлыг нэг уутнаас гаргаж, нөгөө уут уруу дахин савлахыг хатуу хориглоно.

12.6. Хог хаягдлыг халдвартай бүсээр гадагш гаргана. Улаан бүсээс шууд гадагш гарсан хаалгагүй, ногоон бүсээр гаргах бол хог хаягдлын уут, савны гадна талыг шар бүс дээр арчиж халдваргүйжүүлнэ.

12.7. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг битүүмжлэл сайтай, тагтай, бариултай сав, эсвэл дугуйтай тэргэнцэрт хийж зөөвөрлөнө.

Арван гурав. Өрхийн эрүүл мэндийн төв, амбулатори, клиникт хэрэгжүүлэх арга хэмжээ

13.1. Өвчтнүүдэд утсаар цаг өгч үйлчлэх ба халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчдэд тусламж үзүүлэх хэсгийг, үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгээс тусад нь зохион байгуулна.

13.2. Халуунтай болон халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийг эмнэлэгт ирэхгүй байх, утсаар холбогдох заавар зөвлөмж авах талаар иргэдэд мэдээлэл өгнө.

13.3. Халуунтай болон халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчдэд тусламж үзүүлэх хэсгийг тусад нь зохион байгуулсан бол иргэдэд хаана хандахыг урьдчилан мэдээлсэн байна.

13.4. Хөтөч ажилтан, дуугүй хөтөчийг ажиллуулж, халуунтай болон халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзлэгийн хэсэг рүү чиглүүлэн, бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлнэ.

13.5. Үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахих, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулгыг өгнө.

13.6. Үзлэгийн өрөө бүрт амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодис байрлуулсан байна.

13.7. Үзлэг, оношилгооны явцад халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэж, өрөөнөөс гаргахгүй, өрөөнд нэмж хүн оруулахгүй ба яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад тохиолдолд 1 метрээс дотогш зайд ойртохгүй байна.

13.8. Халдварын сэжигтэй тохиолдлыг мэдээллийн дагуу холбогдох ажилтанд утсаар мэдээлж, тусгаарлах эмнэлэгт шилжүүлнэ.

13.9. Эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд амны хаалтыг тогтмол хэрэглэнэ.

13.10. Үйлчлүүлэгчийг шилжүүлсний дараа эмнэлэгт эцсийн халдваргүйжүүлэлт хийнэ.

Арван дөрөв. Яаралтай тусламжийн дуудлага болон гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх үед хэрэгжүүлэх арга хэмжээ

14.1. Халдварын сэжигтэй тохиолдлын дуудлага хүлээн авсан ажилтан нь дуудлагаар очих эмчид урьдчилан мэдэгдэнэ. Дуудлаганд очиж ажиллах эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөнө.

14.2. Дуудлагаар очсон эмч халдварыг сэжиглэсэн тохиолдолд тусгаарлах эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэн, эмнэлгийн машинаар хүргэж өгнө.

Арван тав. Коронавируст халдвараас бусад тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлэгт хэрэгжүүлэх арга хэмжээ

15.1. Үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны дунд коронавируст халдварын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийнэ.

15.2. Хэвтэн эмчлүүлэгчдээс халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед тусгаарлах өрөөнд шилжүүлэн, лабораторийн шинжилгээнд сорьц авч, шинжилгээний хариу гартал эмчилгээг үргэлжлүүлнэ.

15.3. Халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг шилжүүлэх боломжгүй, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд тухайн эмнэлгийн тусгаарлах өрөөнд тусгаарлаж эмчилнэ. Тусламж үзүүлэх ажилтан, багийг тусад нь томилон ажиллуулна.

15.4. Нэг өрөөнд хамт байсан үйлчлүүлэгч болон бусад хавьтлуудыг бүртгэж, тусгаарлан ажиглалтад авна.

Арван зургаа. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар

16.1. Хамгаалах хувцас, хэрэгсэл нь шингэн нэвчихгүй, чөлөөтэй хөдлөх боломжтой, биеийн хэмжээнд тохирсон байна.

16.2. Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах хэсэгт зөв өмссөн эсэхийг хянах зорилгоор биеийг бүхлээр нь харах боломжтой том хэмжээтэй толь байрлуулсан байна.

16.3. Өмсөх, тайлах аргачлал, дараалал бүхий зурагт хуудас байршуулсан байна.

16.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг зүй зохистой хэрэглэхэд дараах зарчмыг баримтална.

16.5. Айдас түгшүүрт автан, давхарлаж хэрэглэхгүй.

16.6. Тусламж, үйлчилгээг нэг дор үзүүлж, эрүүл мэндийн ажилтны орох давтамжийг багасгана.

16.7. Ижил оношор тусгаарлагдсан бүх үйлчлүүлэгчдэд нэг хамгаалах хувцастайгаа тусламж, үйлчилгээ үзүүлж дуусгана. Үйлчлүүлэгч болон өрөө хооронд хамгаалах хувцсыг дахин солих шаардлагагүй.

16.8. Үйлчлүүлэгчид хүрсэн бол үйлчлүүлэгч хооронд гадна бавчийг солино.

16.9. Хамгаалах хувцас илт бохирдоогүй, урагдаж цоороогүй, нороогүй бол тасралтгүй 4 цаг хүртэл хугацаагаар хэрэглэж болно.

16.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эрүүл мэндийн ажиллагсад хүснэгт 2-т заасан хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

16.11. Эрүүл мэндийн бус байгууллагад ажиллагсад заасан хамгаалах хувцас хэрэгслийг хийж байгаа үйл ажиллагаанаас хамааруулан өмсч хэрэглэнэ (Хүснэгт 3).

Хүснэгт 1. Батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтанг үзлэг, шинжилгээнд хамруулах давтамж

Давтамж, өдрөөр	Бх-ПГУ-ын шинжилгээ	SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуур	Цээж гэрэлд харах эсвэл СТ
Ажлын эхний өдөр	✓		✓
Ажиллах хугацаанд 3-4 хоногийн давтамжтай 3 удаа*		✓	
Ажил дуусах өдөр	✓		✓
Ажиллалтын 7 дахь хоногт	✓		
13 дахь хоногт	✓		✓

Тайлбар.* - хөдөө орон нутагт бх-ПГУ-ын шинжилгээнд тогтмол хамрагдах боломжгүй нөхцөлд SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар шинжилгээнд хамруулж болно.

Гэхдээ эрүүл мэндийн ажилтанг ажлын эхний өдөр болон 13 дахь хоногт бх-ПГУ-ын шинжилгээнд заавал хамруулна.

Хүснэгт 2. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эрүүл мэндийн ажиллагсад хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэл

№	Өмсөх хамгаалах хувцас хэрэгсэл	Хийх ажилбар
1	1. Шүүлтүүртэй амны хаалт (N95 эсвэл FFP2) 2. Комбинзон эсвэл халад 3. Малгай 4. Бээлий 2 давхар 5. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 6. Гутлын гадуур улавч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд дараах аэрозол үүсгэх ажилбар хийх үед; 1. Бронх дурагдах; 2. Интубаци тавих, авах; 3. Амьсгал, зүрхний сэхээн амьдруулах тусламж үзүүлэх (CPR); 4. Зохиомол амьсгал (маск, интубаци); 5. Соруулга хийх; 6. Амьсгалын замд хийгдэх мэс засал; 7. Шүдний эмчилгээ, өрөм, борын машин ажиллуулан тусламж үзүүлэх Хамар, залгиураас сорьц авах SARS-CoV-2 илрүүлэх шинжилгээ хийж байгаа ажилтан
2	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Шингэн нэвчихгүй, ариун халад 3. Малгай 4. Ариун бээлий 2 давхар 5. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 6. Гутлын гадуур улавч 7. Шингэн нэвчих эрсдэл их бол нэг удаагийн хормогч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд амьсгалын замаас бусад мэс заслын тусламж үзүүлэх Ариун нөхцөлд хийгдэх ажилбар гүйцэтгэх Коронавируст халдвар (COVID-19)-тай эхийн төрөлт удирдах, эх барихын тусламж үйлчилгээ үзүүлэх үед
3	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад эсвэл комбинзон 3. Малгай 4. Бээлий 2 давхар 5. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 6. Гутлын гадуур улавч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд үзүүлэх бусад үзлэг, эмчилгээ, оношлогооны үед Кабин тусгаарлагдаагүй нөхцөлд батлагдсан, сэжигтэй тохиолдлыг зөөх, тээвэрлэх жолооч, эмч
4	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад эсвэл комбинзон 3. Малгай 4. Нэг удаагийн үзлэгийн бээлий 5. Ахуйн бээлий 6. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 7. Усны гутал	Үйлчилгээний болон ариутгалын ажилтан коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөний өрөөг цэвэрлэх, халдваргүйжүүлэх үед Багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх үед Хог хаягдлыг зөөх, тээвэрлэхэд
5	1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 2. Халад 3. Нүүрний хаалт	Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан, сэжигтэй тохиолдлыг тээвэрлэхэд жолооч өвчтөнд хүрэхгүй, кабин тусгаарлагдсан үед Нийт хүн амын дунд халдвар тархах эрсдэл өндөртэй үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүх ажилтан
6	1. Амны хаалт	Эрүүл мэндийн байгууллагын захиргаа, оффисын бусад ажиллагсад

Хүснэгт 3. Эрүүл мэндийн бүс байгууллагад ажиллагсадын өмсөх хамгаалах хувцас хэрэгсэл

№	Өмсөх хамгаалах хувцас хэрэгсэл	Хийх үйл ажиллагаа
1	1. Амны хаалт 2. Халад 3. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 4. Бээлий 1 давхар 5. Малгай	Ажиглалтын байранд ажиллах эрүүл мэндийн ажилтан үзлэг хийх, хог хаягдалтай харьцахад Нийтийг хамарсан халдвар, халдвар бүртгэгдсэн орон нутагт явж буй агаарын хөлөг болон галт тэрэг, автобусанд орж ажиллах үйлчилэгч, билет шалгагч, эмч, мэргэжлийн хяналтын байцаагч, бусад ажилтан Коронавируст халдвар (КОВИД-19) бүртгэгдсэн улс орноос иргэдийг татан авах үйл ажиллагаанд
2	1. Амны хаалт 2. Халад эсвэл комбинзон 3. Нүдний шил эсвэл нүүрний хаалт 4. Үзлэгийн бээлий 5. Малгай 6. Усны гутал/ гутлын гадуурх улавч	Ажиглалтын байранд халдварын шинж тэмдэг илэрсэн хүнд тусламж үзүүлэх эрүүл мэндийн ажилтан Ажиглалтын байранд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх ажилтан Хилийн нэвтрэх цэгт ажиллаж байгаа халдваргүйжүүлэлт хийх ажилтан
3	1. Амны хаалт	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтот бүс нутгаас ирсэн ачаа тээштэй харьцах үед Агаарын хөлгийн нисгэгч, галт тэрэгний машинист нь үйлчлүүлэгчтэй харьцахгүй бүрэн тусгаарлагдсан нөхцөлд ажиллаж байгаа тохиолдолд Ажиглалтын байранд үйлчлүүлэгчтэй шууд харьцахгүйгээр хоол болон эргэлтийн зүйлсийг түгээх үед Тусгаарлах хаалтны цаанаас харьцаж байгаа үйлчилгээний ажиллагсад Цагдаа, онцгой байдлын ажилтан, гал тогооны ажилтнууд үйлчлүүлэгчтэй шууд харьцаагүй тохиолдолд

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 07 сарын 19 өдрийн 19 тушаалын
дөрөвдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд энэхүү түр зааврыг мөрдөнө.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед урьдчилан сэргийлэх болон голомтын (байнгын, эцсийн) халдваргүйжүүлэлт хийнэ.

1.3. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг цар тахлын үед олон нийтийн дунд өвчтөн болон хавьтлуудын халдвар дамжих замыг таслан зогсоох зорилгоор хийнэ.

1.4. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг цар тахлын үед байгууллага аж ахуйн нэгж зааврын дагуу тогтмол хийнэ.

1.5. Голомтын байнгын халдваргүйжүүлэлт нь өвчтөн байрлаж буй эмнэлгийн өрөөнд өдөр тутам хийгдэнэ.

1.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг гэр орон, ажлын байр, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан болон тусгаарласан өрөө, тээвэрлэсэн машин, нас барсан тохиолдолд цогцос зөөсөн дамнуурга, өрөө, тавиур, хөргөгч зэрэг халдвар дамжих эрсдэлтэй хэсгүүдэд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийнэ.

Хоёр. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт

2.1. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг сар тутам, шаардлагатай тохиолдолд 14 хоногт 1 удаа гэрээт аж ахуйн нэгж, шавж, мэргэч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай заавшеерал бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Гурав. Голомтын халдваргүйжүүлэлт

3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагааг Зоонозын өвчин судлалын үндэсний төв мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

3.2. Тэргүүлэх байгууллага, Эрүүл мэндийн мэргэжлийн алба, тохиолдлын удирдлагын тогтолцооноос өгсөн тархвар судлалын дүгнэлт, мэдээллийн (хамрах хүрээ, хаяг, байршил) дагуу холбогдох байгууллагын томилогдсон шуурхай хариу арга хэмжээний баг голомтын халдваргүйжүүлэлтийг зохион байгуулан ажиллана.

3.3. Тухайн эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний баг нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудын тусгаарлагдан эмчлэгдэж байгаа үеийн халдвар хамгааллын дэглэм, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж ажиллана.

3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тухайн эмнэлгийн шуурхай хариу арга хэмжээний баг гүйцэтгэнэ.

3.5. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, айл өрх, харьяа аймаг, нийслэл, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний баг халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэнэ.

3.6. Гадаад улс орноос иргэдийг татан авалт хийж буй тусгай үүргийн онгоц, хот хооронд нислэг үйлдэж буй дотоодын онгоц, ачаа тээврийн онгоц, цэргийн зориулалттай тусгай үүргийн болон дипломат шугамаар ирж буй онгоц, тэдгээрийн ачаа тээшинд эцсийн халдваргүйжүүлэлтийг Хилийн мэргэжлийн хяналтын алба зохион байгуулан ажиллана.

3.7. Галт тэрэг, ачааны машин, чингэлэг, ачаа, тээшийн халдваргүйжүүлэлтийг Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт дор тухайн тээвэр зуучийн байгууллага бүрэн хариуцаж гэрээт ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.8. Орон нутаг, хот хоорондын зорчигч болон ачаа тээврийн хэрэгсэлийн халдваргүйжүүлэлтийг гэрээт ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн өвчтөн нь гэрээр эмчлүүлэх шаардлагатай болсон тохиолдолд халдваргүйжүүлэлтийг эрүүл мэндийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийн дагуу өөрсдөө тогтмол хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх аргачлал

4.1. Шуурхай хариу арга хэмжээний багийн үүрэг, үйл ажиллагааны дараалал:

4.1.1. Голомтод халдваргүйжүүлэлт хийх багийн бүрэлдэхүүнд тархвар судлаач/халдвар судлаач, ариутгагч, жолооч нар багтах бөгөөд тархвар судлаач/халдвар судлаач эмчийн хяналт дор ажиллана.

4.1.2. Багийн гишүүд нь тархвар судлаач/халдвар судлаач эмчийн хамт халдваргүйжүүлэлтэд шаардлагатай хамгаалах хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сав суулга, ахуйн эд зүйлс, халдваргүйтгэлийн бодис зэргийг нарийвчлан тооцож, жагсаалтын дагуу бэлэн болгон дуудлаганд авч явна.

4.1.3. Ойрын хавьтал, өвчтөн, цогцос зөөвөрлөсөн (нүүлгэн шилжүүлсэн) тээврийн хэрэгсэлд тухай бүр эцсийн халдваргүйжүүлэлтийг заавал хийнэ.

4.1.4. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх багийн гишүүд нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас хэрэгсэлийг халдвараас сэргийлэх зааврын дагуу халдваргүй бүс буюу ногоон бүсэд өмснө.

4.1.5. Халдваргүйжүүлэлт хийж дууссаны дараа хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгсэлийг зааврын дагуу шар бүсэд тайлна.

4.1.6. Өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлт хийхдээ гар хүрэх газар, гадаргуу болон тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг арчиж, тааз хананы дээд хэсэг, их талбайг шүршиж, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг арчиж халдваргүйжүүлнэ.

4.1.7. Голомтын халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүд хэрэглэсэн хамгаалах хувцас, цаварлэгээний материал, хог хаягдал зэргийг халдвартай хог, хаягдал цуглуулах шар уутанд хийж, савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршиж, зөөвөрлөж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог

хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар"-ын дагуу устгана.

4.1.8. Голомтын халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүд коронавирусийн халдвар (КОВИД-19)-ын нууц үеийн хугацааг дуустал биеийн халуунаа тогтмол үзэж, биеийн байдалд ажиглалт хийнэ.

4.1.9. Хэрэв халуурах, ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй болох, гүйлгэх, үнэрлэх, амтлах мэдрэмж алдагдах зэрэг шинж тэмдэг илэрвэл байгууллагын эмч, тархвар судлагч болон захиргаанд мэдэгдэж оношийг яаралтай тодруулах, холбогдох арга хэмжээг авна.

4.1.10. Голомтод ажилласан илтгэх хуудсыг бичиж холбогдох газарт хүргүүлнэ.

4.2. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэх багаж, хэрэгсэл

4.2.1. Хамгаалах хувцас хэрэгсэл (хамгаалах хувцас хэрэгсэлийг 1-2 ширхэг илүү авч явна)

4.2.2. Автомакс (мананцар үүсгэгч)

4.2.3. Уусмал нойруулах сав

4.2.4. Хэмжээст сав

4.2.5. Хар, шар өнгийн хогийн уут, хог хийх тагтай сав

4.2.6. Нүдний шил халдваргүйжүүлэх спирт, сав

4.2.7. Халдваргүйжүүлэх уусмал

4.2.8. Гар халдваргүйжүүлэх бодис

4.3. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхэд анхаарах зүйлс

4.3.1. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө бүх хүмүүсийг өрөөнөөс гаргаж, цонх, хаалгыг хааж, цахилгаан хэрэгслийг тогноос салгана.

4.3.2. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө дахин хэрэглэх аяга, таваг, гал тогооны хэрэгслийг уутанд хийж, 2%-ийн содын уусмалд 30 минут буцалгахыг зөвлөнө.

4.3.3. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхээс өмнө задгай хоол хүнс болон өвчтөний хэрэглэж байсан хоолны үлдэгдлийг шүршиж, хог хаягдлыг шар өнгийн уутанд хийж Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 тоот тушаалын дагуу устгана.

4.3.4. Хөнжил, дэр, гудас зэрэг зөөлөн эдлэлийг дезкамер ашиглан халдваргүйжүүлнэ. Үүнд шуурхай хариу арга хэмжээний баг

4.3.5. Хөргөгчний гадна талыг шүршиж дотор талыг 2%-ийн содын уусмалаар арчиж халдваргүйжүүлэн хаалгыг онгорхой орхино.

4.3.6. Агааржуулалтын хоолой руу шүрших аргаар халдваргүйжүүлнэ.

4.4. Өвчтөний явсан зам маршрутын дагуу халдваргүйжүүлэлт, хийх дараалал

4.4.1. Өвчтөнийг зөөвөрлөсөн машины зогсоол-байрнаас гарсан зам – байрны хаалганы бариул (гадна ба дотор тал) - хөл арчдаг дэвсгэр-үүдний танхимын агаарт жавелионы 0,06%-ийн уусмалыг 1м^2 талбайд 100 мл уусмал орохоор тооцож, шүршиж халдваргүйжүүлнэ.

4.4.2. Шат-шатны бариул – хажуу хана-лифтний хаалга, шал, лифтэн доторхи агаар – хана, тааз зэргийг шүршиж, товчлуурыг арчиж халдваргүйжүүлнэ.

4.4.3. Өвчтөн тусгаарлагдаж байсан давхарт гарч агаар – шал – хана – давхрын өрөөнүүдийн хаалга зэргийг коридорын эцэс хүртэл шүршиж халдваргүйжүүлсэний дараа өрөөний үүдэнд буцаж ирнэ.

4.4.4. Өрөөний хаалганы гадна тал, бариул, дотор талыг шүршиж халдваргүйжүүлсэний дараа хаалгыг нээж өрөөний агаарт 1 минутын турш мананцар үүсгэж шүршинэ.

4.5. Өрөөнд халдваргүйжүүлэлт хийх дараалал

4.5.1. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг байрны гадна талын хаалганаас эхлэн гадна талаас дотогш дээрээс доош гэсэн чиглэлээр хийнэ.

4.5.2. Хаалганы гадна, дотор талын бариул – өрөөний агаар – хана, шал – цонх, цонхны тавцан – хөшиг – тавилгын гадна, дотор тал – хөнжил, дэвсгэр даавуу, гудасны бүх гадаргууг бүрэн шүршиж хогийн савны дотор гадна талыг шүршинэ.

4.5.3. Телевизор, компьютер зэрэг цахилгаан хэрэгсэлийг тогноос бүрэн салгасаны дараа шүршиж, уусмалын манан буусны дараа халдваргүйжүүлэх уусмалтай алчуураар арчина.

4.5.4. Ор дэрний цагаан хэрэглэлийг зөөлөн хөдөлгөөнөөр сугалан авч жавелионы 0.06%-ийг уусмалд бүрэн живүүлж орхино.

4.5.5. Ванн-шүршүүр-угаалтуур-суултуурыг шүршиж, суултуурт гипохлорид кальци 200 гр хийж тагийг таглаж орхино.

4.5.6. Халдваргүйжүүлэлт хийснээс хойш 1-2 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийж, өрөөг агааржуулна.

Хүснэгт. Халдваргүйжүүлэх бодисын найрлага, хэрэглэх арга

№	Бодисын нэр	Ажлын уусмал	Бодисын хэмжээ	Уусмалын хувь	Хэрэглэх зориулалт
1.	Клорсепт	5 л	1 ш	0,02%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		2 л	1 ш	0.05%	Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
2.	Жавелион	10 л	1 ш	0.015%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		10 л	2 ш	0,03%	Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		10	4 ш	0,06%	Голомтын эцсийн халдваргүйтэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу

					гадаргуу, бүх төрлийн зөөлөн адлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ.
		10	7	0.1%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
3.	ДП-2Т	7.5	1	0.02%	Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хавлганы бариул, хана, цонх, шал, ширээ сэндал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
		7.5	2	0.04%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сэндал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн адлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ.
		7.5	5	0.1%	Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ.
4.	40%-ийн гипо хлорид кальци /хуурай/	10	50 гр	0.2%	Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цорногийг халдваргүйжүүлнэ.
		10	125 гр	0.5%	Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цорногийг халдваргүйжүүлнэ.
5.	Содын уусмал	1 л	20гр	2%	Бүх төрлийн хүүхдийн тоглоомыг халдваргүйжүүлнэ.
6.	Гипохлорид натри Белезна	9860 мл	150мл		Шал хавлганы бариул гэх мэт хатуу гадаргуу
		9400 мл	600 мл	1%	Ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 01 сарын 17 өдрийн тушаалын
тавдугаар хавсралт 19

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГООНЫ ТҮР ЗААВАР

Нэг. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй гэж оношилсон тохиолдлоос сорьц авах, хадгалах, тээвэрлэх

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг оношилсон эмч, сувилагч эмчилгээ эхлэхээс өмнө сорьц авна.

1.2. Батлагдсан тохиолдлын хавьтлууд эмнэлгээс хол байгаа үед шуурхай хариу арга хэмжээний баг явж сорьц авна.

1.3. Сэжигтэй тохиолдол бүрээс хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, амьсгалын дээд замын хүнд хэлбэрийн өвчтэй бол цэр, амьсгалын гуурстай бол мөгөөрсөн хоолойн сордос, мөгөөрсөн хоолой-альвеолын лаваж авна. Нэмэлтээр цус, шээс, өтгөн, шаардлагатай бол уушигны эд, эсийн сорьц авч шинжилнэ.

1.4. Сорьц авах үед өрөөнд байх хүний тоог аль болох цөөлж, зөвхөн өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг байлцуулна.

1.5. Шинжлэгдэхүүн авах эрүүл мэндийн ажилтан нь хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсч, HEPA шүүлтүүр бүхий N95 амны хаалт, нүдний шил, нүүрний халхавч зүүнэ.

Хоёр. Сорьц цуглуулахад шаардагдах зүйлс

- 2.1. Шингэн үл нэвтрүүлэх материалаар хийгдсэн халад
- 2.2. N95 амны хаалт
- 2.3. Нүдний хамгаалалт (нүдний шил буюу нүүрний халхавч)
- 2.4. Эмнэлгийн бээлий
- 2.5. 7-8 см урт уян эсвэл иштэй ариун бамбар
- 2.6. Хэл дарагч
- 2.7. 2-4 мл вирус зөөвөрлөх орчин эсвэл 0,9% натри хлорид бүхий бөглөөтэй хуруу шил
- 2.8. Хуруу шил тогтоогуур
- 2.9. Цэрний сав
- 2.10. Сорьц зөөвөрлөх зориулалтын сав
- 2.11. Сорьц дагалдах хуудас
- 2.12. Шилний маркер

Гурав. Лабораторийн шинжилгээнд сорьц авах

3.1. Хамар-залгиурын арчдас авах: Өвчтний нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлээд, насанд хүрэгчдийг хэвтүүлж, хүүхдийг хүнд тэврүүлж суулгана. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар өвчтний хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж, болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын хөндийн самалдаг руу насанд хүрэгч бол 4-5 см, хүүхэд бол 2-3 см оруулан, бамбараа салст бүрхүүл рүү шахаж эргүүлэн арчдас авч,

зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсвэл 0,9% натри хлорид бүхий хуруу шилэнд хийнэ.

3.2. Ам-залгиурын арчдас авах: Өвчтнийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад амыг ангайлгаж, хэл дарагчаар хэлийг дарж, залгиурын арын ханыг хатуу иштэй ариун бамбараар арчиж авна. Арчдсыг зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсвэл 0,9% натри хлорид бүхий хуруу шилэнд хийнэ.

3.3. Цэр авах:

3.3.1. Амыг усаар сайтар зайлуулж, амны хөндийг цэвэрлэн, хамар ба хоолойн салс, шүлс зэргийг аль болох оруулахгүй авна.

3.3.2. Амьсгалыг гүнзгий авахуулан, түгжин 2 секунд орчим болсны дараа аажим гаргуулж, 2-оос доошгүй удаа давтана.

3.3.3. Гурав дахь удаагаа амьсгалыг гүнзгий авахуулж, хүчтэй ханиалгуулан цээжний гүнээс цэрийг гаргуулна.

3.3.4. Гаргасан цэрийг цэр цуглуулах саванд хийнэ. Цэрний хэмжээ 3-5 мл байна.

3.3.5. Цэрийг агааржуулалт сайтай, зориулалтын өрөөнд эсвэл гадна орчинд авна.

3.4. Ийлдэс цуглуулах: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдварын эсрэг цусанд үүссэн өвөрмөц эсрэг биеийн танцыг тодорхойлох шаардлагатай үед 14-21 хоногийн зайтай хос ийлдсийг авна.

3.5. Эд, эсийн сорьц авах: Уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй огтолж аваад, ариун саванд эсвэл зориулалтын вирус тээвэрлэх уусмал бүхий хуруу шилэнд хийж сайн таглана.

Дөрөв. Сорьцыг хадгалах, зөөвөрлөх

4.1. Хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, мөгөөрсөн хоолойн сорьцыг 24-48 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, нэмэх 2-8°C хэмд тээвэрлэж, лабораторид хүргэнэ. 48 цагийн дотор тээвэрлэх боломжгүй бол хасах 70°C хэмд хадгалж хөлдүүгээр тээвэрлэж, лабораторид хүргүүлнэ.

4.2. Эд, эсийн сорьцыг нэмэх 2-8°C хэмд тээвэрлэж, лабораторид яаралтай хүргэнэ. Боломжгүй бол хасах 70°C хэмд хадгалж, хөлдүүгээр тээвэрлэнэ.

4.3. Ийлдсийг 7 хоногийг дотор 2-8°C хэмд хадгалж тээвэрлэнэ, боломжгүй бол хасах 20°C-д хадгалж, хөлдүүгээр лабораторид хүргэнэ.

4.4. Сорьцыг тээвэрлэхийн өмнө ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ, бусад Вирус судлалын лабораторит урьдчилан мэдэгдэнэ.

4.5. Сорьцыг асгарахаас сэргийлэн био аюултай илгээмж, био бэлдмэл тээвэрлэх журмын дагуу 3 суурьт савлалтын аргаар савлана. Сорьц цуглуулсан савны гадуур амыг нь битүүмжлэх боломж бүхий уутанд хийж, гадна талд нь "Биоаюултай", "Халдвартай" гэсэн тэмдэглэгээг хийж тээвэрлэнэ. Уутанд хийсэн сорьцыг мөсөн элемент бүхий сорьц зөөвөрлөх зориулалтын саванд хийж тээвэрлэнэ.

4.6. Сорьцын дагалдах хуудсыг гаргацтай, бүрэн бөглөж сорьцын хамт лабораторид хүргүүлнэ (хавсралт 1).

Тав. Лабораторийн шинжилгээ хийх

5.1. Коронавирус (SARS-CoV-2) илрүүлэх бодит хугацааны полимеразын гинжин урвал (бх-ПГУ) шинжилгээгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг

баталгаажуулна. Мөн SARS-CoV-2 вирусийн антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар шинжилнэ.

Зургаа. Лабораторийн шинжилгээ хийх давтамж, төрөл, мэдээлэл

6.1. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь өдөр бүр лабораторийн шинжилгээ, үр дүнгийн талаарх мэдээг Эрүүл мэндийн яамнаас зөвлөмж болгосон цахим мэдээллийн санд оруулна.

6.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтнийг илрүүлэх, хавьтлыг судлах, халдвар зөөвөрлөгдөхөөс сэргийлэх үүднээс лабораторийн шинжилгээг дараах төрөл, давтамжтайгаар хийнэ (Хүснэгт).

Хүснэгт. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хийгдэх шинжилгээний төрөл, давтамж

№	Хамрагдах хүн	Шинжилгээний төрөл	Давтамж			Тайлбар
			Эхний өдөр	6 дахь хоног	13 дахь хоног	
1	Гадаад улс, орноос ирж ажиглалт, тусгаарлалтад хамрагдсан иргэд	бх-ПГУ-ын шинжилгээ	+		+	Гэрийн ажиглалтын 7 хоногт шинжилгээ хийх эсэхийг эмнэлзүй, тархвар зүйн асуумжинд үндэслэн шийдвэрлэнэ.
1	Гадаад улс, орноос ирэхдээ тухай газраа дархлаажуулалтанд хамрагдсан иргэд	бх-ПГУ-ын шинжилгээ	+	+		Гэрийн ажиглалтын 7 хоногт шинжилгээ хийх эсэхийг эмнэлзүй, тархвар зүйн асуумжинд үндэслэн шийдвэрлэнэ.
2	КОВИД-19 халдвар бүртгэгдсэн газарт голомтод үүрэг гүйцэтгэсэн албан ажилтан	бх-ПГУ-ын шинжилгээ	+	+		
3	КОВИД-19 халдвар бүртгэгдсэн газарт голомтод үүрэг гүйцэтгээгүй албан ажилтан		+			
4	КОВИД-19 халдвар бүртгэгдсэн голомтод бүс нутгаас халдвар бүртгэгдээгүй нутагт зорчих иргэн	бх-ПГУ-ын шинжилгээ	72 цагийн өмнө сайн дураар бх-ПГУ шинжилгээнд хамрагдсан байх			Антиген илрүүлэх түргэвчилсэн оношлуураар зэрэг бол бх-ПГУ шинжилгээнд хамруулна.
		Антиген илрүүлэх түргэвчилсэн оношлууур	+			
5	Орон нутагт ажиглалт,	Эмнэлзүй, тархвар судлалын асуумжинд үндэслэн лабораторийн шинжилгээ хийх эсэхийг тухайн өрх, сумын ЭМТ шийдвэрлэнэ.				

	тусгаарлалтын 14 хоног дууссан иргэн					
6	Эрсдэл өндөртэй 1-р хавьтал	бх-ПГУ-ын шинжилгээ	+	+		Ажиглалтын хугацаанд эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл хугацаа харгалзахгүйгээр бх-ПГУ шинжилгээнд хамруулна
7	Эрсдэл багатай 1-р хавьтал 2-р хавьтал	Шаардлагатай тохиолдолд бх-ПГУ-ын шинжилгээнд хамруулна.				
8	Сэжигтэй тохиолдол	бх-ПГУ-ын шинжилгээ	+			
9	Магадлалтай тохиолдол	бх-ПГУ-ын шинжилгээ	+	+	+	Уушгины хатгалгааны бүх хэлбэр магадлалтай тохиолдолд хамаарна.

Хавсралт 1. Сорьц дагалдах хуудас №...../.....

Эрүүл мэндийн байгууллагын нэр

Үйлчлүүлэгчийн эцэг /эх/-ийн нэр, Нэр.....

Нас: Хүйс: Эрэгтэй ☐ Эмэгтэй ☐

Регистрийн дугаар: ☐☐☐☐☐☐☐☐☐☐

Оршин суугаа хаяг:

Эмнэлзүйн онош:

Өвчин эхэлсэн огноо: _____ оны _____ сарын _____ өдөр

Эмнэлэгт хэвтсэн огноо: _____ оны _____ сарын _____ өдөр

Сорьц авсан огноо: _____ оны _____ сарын _____ өдөр _____ цаг _____ минут

Сорьц авах үеийн биеийн хэм: ☐☐☐☐ °C

Цуглуулсан сорьцын төрөл:

Хамар-залгиурын арчдас	☐
Ам-залгиурын арчдас	☐
Мөгөөрсөн хоолойн сордос	☐
Бусад	☐

Шинжилгээний зорилго

а. Зорилтот:

i. Хавьтал

ii. Байгууллагад суурилсан

1. Төрийн байгууллага

2. Хувийн хэвшлийн байгууллага

3. Тусгаарлах байр

b. Сайн дураар

c. Бусад

Сорьцыг тээвэрлэлтэд өгсөн: огноо: _____ оны _____ сарын _____ өдөр _____ цаг _____ минут

Шинжилгээ хийсэн байгууллага:

Сорьц авсан мэргэжилтэний нэр:

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 01 сарын 29 өдрийн 9/тушаалын
зургаадугаар хавсралт 29

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судалгааны хуудас

1. Ерөнхий мэдээлэл:	
Сэжигтэй ☐	Магадлалтай ☐ Батлагдсан ☐
Хэрэв батлагдсан бол: Анхдагч ☐ Хоёрдогч ☐ Зөөвөрлөгдсөн ☐	
Батлагдсан тохиолдлын дугаар	
Биеийн байдал	Маш хүнд ☐ Хүнд ☐ Хүндэвтэр ☐ Дунд ☐ Хөнгөн ☐ зовиургүй ☐
Мэдээлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Судалгаа эхэлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Судалгаа авсан хүний овог, нэр _____ ажлын газар _____, албан тушаал, утасны дугаар	
Асуумжинд хариулж буй хүний овог, нэр _____, өвчтний хэн болох _____, гэрийн хаяг _____, утасны дугаар	
(өөчтөн маш хүнд, асуумжинд хариулах боломжгүй, нас барсан бол хамаарал бүхий иргэнээс асуумж авна)	
Тохиолдлыг илрүүлсэн байдал	Идавхтэй тандалтаар ☐ өөрөө ирсэн ☐ хилийн нэвтрэх цэгт ☐ түргэн тусламжаар ☐ өөр эмнэлгээс шилжиж ирсэн ☐ бусад _____
Эмнэлэгт үзүүлсэн огноо	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут
Эмнэлэгт хэвтсэн эсэх	Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй ☐ Тийм бол огноо: ___ он ___ сар ___ өдөр Хэвтсэн эмнэлгийн нэр _____
Халдварын эх уурхай тогтоогдсон эсэх? Тийм ☐ Үгүй ☐	
Хэрэв тийм бол эх уурхай болсон өвчтөний овог _____ нэр _____ нас хүйс: Эрэгтэй ☐ Эмэгтэй ☐	
Хавьтал болсон газар: Өрх/Гэр ☐ Эмнэлэг/ЭМБ ☐ Ажлын газар ☐ Сургууль/цэцэрлэг ☐ Бусад (бичнэ үү) _____	
Хавьтал болсон байдла: Шууд хүрэлцсэн ☐ Шууд хүрэлцээгүй нэг метрээс дотогш зайнд харьцсан ☐ Өвчтөний эргэн тойрны эд юмст хүрэлцсэн ☐ Тодорхойгүй ☐ бусад (бичнэ үү) _____	
Анх хавьтал болсон огноо: ___ он ___ сар ___ өдөр	
☐ Эрсдэл өндөртэй 1-р хавьтал ☐ Эрсдэл багатай 1-р хавьтал	
Хавьтал хугацаа: Үрт (>1 хоног) ☐ Дунд (цагаар) ☐ Богино (минутаар) ☐	
2. Хүн ам зүйн мэдээлэл:	
Овог:	Нэр:
Нас (жил, сараар): жил сар	Хүйс: Эрэгтэй ☐ Эмэгтэй ☐
Регистрийн дугаар	Төрсөн огноо: ___ он ___ сар ___ өдөр
Утасны дугаарууд	
Иргэншил	
Гэрийн хаяг	
Хэрэв гадаадын иргэн бол байрлаж буй газар, хаяг	Байрлаж буй газрын нэр: _____ Дэлгэрэнгүй хаяг: _____

Нийгмийн байдал	Албан хаагч ☐ , Ажилчин ☐ , Ажилгүй ☐ , Оюутан ☐ , Сурагч ☐ , Хувиараа ☐ , Тэтгэвэрт ☐ , Малчин ☐ , Цэцэрлэг ☐ , Гэрт ☐ , Бусад:
Ажлын газрын хаяг (ажил, сургууль, цэцэрлэг)	
Мэргэжил, албан тушаал	
Ам бүлийн тоо	☐ ☐

3. Илэрсэн эмнэлзүйн шинж тэмдгүүд	Тийм бол илэрсэн огноо		
Халуурах ($\geq 37.1^{\circ}\text{C}$)	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
	Хэм $^{\circ}\text{C}$ _____ он _____ сар _____ өдөр		
Хоолой хөндүүрлэх/өвдөх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Хуурай ханиалгах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Нусгайрах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Хамар битүүрах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Үнэрлэх мэдрэхүй алдагдах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Амтлах мэдрэхүй алдагдах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Амьсгал давчдах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Жихүүдэс хүрэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Бөөлжих	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Дотор муухайрах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Суулгах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Толгой өвдөх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Тууралт гарах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Нүд урвсах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Булчингаар өвдөх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Үе мөч өвдөх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Хоолонд дургүй болох	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Хамраас цус гарах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Ядоах, сульдах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Татах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Ухаан балаартах	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Мэдрэлийн бусад шинж тэмдэг	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Бусад шинж тэмдэг	Тийм бол бичнэ үү:		
	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
	Тийм бол бичнэ үү:		

4. Халдвартай байсан хугацаа: _____ он _____ сар _____ өдрөөс _____ он _____ сар _____ хүртэл (Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн бол илрэхээс өмнөх 2 хоног, илрээгүй бол сорьц авсан өдрөөс өмнөх 2 хоногоос эхлэн тооцно)

5. Эрсдэлт хүчин зүйлс:			
Таргалалттай эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Хоот хавдраар өвчилсөн эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Чихрийн шинжтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
ХДХВ/бусад дархлаа дарангуйлагдах өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Зүрх судасны эмгэг өвчтэй эсэх /АДИӨ гэх мэт/	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Багтраа өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Багтраанаас бусад уушгины ярхаг өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐

Элэгний архаг өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Цусны архаг өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Жирэмсэн эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
	Хэрэв тийм бол: жирэмслий хугацаа:..... Төрөх хугацаа:.....		
Бөөрний архаг өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Мэдрэлийн архаг өвчин, эмгэгтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Эрхтэн, чамар шилжүүлэн суулгуулсан эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐
Бусад хавсарсан өвчтэй эсэх	Тийм ☐	Үгүй ☐	Мэдэхгүй ☐

5. Сүүлийн 14 хоногийн хугацаанд халдварт өртөх эрсдэл

Халдварт өртсөн байж болох эрсдэл	Тийм бол хаана	Тийм бол хэзээ	Хугацаа (хоног)
Аялсан эсэх Тийм ☐ Үгүй ☐			
Гадаад оронд амьдарч, сурч байгаад ирсэн эсэх Тийм ☐ Үгүй ☐			
Ирсэн бол нэрлэн бичих			
Олон нийтийн арга хэмжээнд оролцсон эсэх Тийм ☐ Үгүй ☐			
Амьсгалын замын халдварын сэжигтэй хүнтэй хамт байсан эсэх Тийм ☐ Үгүй ☐			
Ажил, сургууль, цэцэрлэгт явсан эсэх Тийм ☐ Үгүй ☐			

Эрүүл мэндийн байгууллагад хандсан эсэх: Тийм ☐ Үгүй ☐ Хэрэв тийм бол:			
Хандсан шалтгаан	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Хэзээ (огноо)	Хэдэн удаа
Эмнэлэгт үзүүлсэн			
Шинжилгээ өгсөн			
Хэвтэн эмчлүүлсэн			
Өвчтөн асарсан			
Хүн үзүүлэхээр хамт явсан			
Тусгаарлагдсан эсэх	Тийм ☐ Үгүй ☐ Хэрэв тийм бол: Эмнэлгийн нэр:..... Тусгаарлагдсан огноо:		

6. Вирус судлалын шинжилгээний дүн						
Сорьц ын нэр	Дазтамж	Сорьц авсан огноо	Лабораторийн нэр	Шинжилгээний төрөл	Шинжилгээний хариу	Хариу гарсан огноо
Хамар залгиу рын арчдас	Сорьц 1					
	Сорьц 2					
	Сорьц 3					
	Сорьц 4					
Ам залгиу рын арчдас	Сорьц 1					
	Сорьц 2					
	Сорьц 3					
	Сорьц 4					
Бусад (бичих)						

7. Нян судлалын шинжилгээний дүн (хоёрдогч халдвар)		
Сорьц авсан огноо ____ он ____ сар ____ өдөр	Сорьцын төрөл Цэр ☐ Гуурсан хоолойн сордос ☐ Плеврийн шингэн ☐ Нугасны шингэн ☐ Цус ☐ Шээс ☐ Өтгөн ☐ Бусад	Илэрсэн нян Haemophilus influenza ☐ MRSA ☐ Staphylococcus aureus ☐ Streptococcus pneumonia ☐ E.coli ☐ Бусад
9. Тавилан: Эдгэрсэн ☐ , Сайжирсан ☐ , Нян тээгч ☐ , Нас барсан ☐ Эдгэрсэн бол эмнэлгээс гарсан огноо: Нас барсан бол огноо: Задлан шинжилгээ хийсэн бол огноо: Задлан шинжилгээ хийсэн шалтгаан: Задлан шинжилгээний дүгнэлт:		
10. Батлагдсан тохиолдлын хавьтлын талаарх товч мэдээлэл: Эрдэл өндөртэй болон эрдэл багатай хавьтал болсон нийт хүний тоо ☐ үүнээс гэртээ ☐ , бусад газарт ☐ 2-р хавьтлын тоо Хавьтлаас КОВИД-19 халдвараар өвчилсөн нийт хүний тоо ☐		
10. Эцсийн онош		
11. Эцсийн дүгнэлт: Сэжигтэй ☐ , Магадлалтай ☐ , Батлагдсан ☐ Онош үгүйсгэгдсэн ☐ Батлагдсан бол тэрхээр судалгаагаас ☐ , эмнэл зүйгээр ☐ , лабораториор ☐ Хэрэв онош үгүйсгэгдсэн бол оношийг бичих Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар эсэх: Тийм ☐ Үгүй ☐ Эцсийн дүгнэлт гаргасан тархээр судлаачийн овог, нэр Албан тушаал утасны дугаар		
Анхааруулга: Батлагдсан тохиолдлын голомтонд авч хэрэгжүүлсэн шуурхай хариу арга хэмжээ, хавьтлуудын талаарх мэдээллийг уг судалгааны хуудсанд хавсаргана.		

12.2. Бусад газарт хавьтал болсон (ажлын газар, олон нийтийн бусад газарт хавьтал болсон иргэдийг хамруулна)

[illegible]

12.3. 2-р хавьтлын жагсгалт

[illegible]

Эрүүл мэндийн сайдын
оны 01 сарын 29 өдрийн 87 тушаал
долоодугаар хавсралт 29

ртэй, багатай 1-р хавьтлыг
удас

Батлагдсан тохиолдлын эрсдэл өндөртэй, багатай 1-р хавьтлын ажиглалтын хуудас

[illegible]

5	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
6	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
7	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
8	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
9	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
10	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
11	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
12	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
13	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
14	Орой	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй
	Өглөө	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй	Тийм Үгүй

2. Хавьтлыг шинжилгээнд хамруулсан байдал				
Шинжилгээний давтамж	Хамрагдсан огноо	Авсан оорьцын төрөл	Хийгдсэн шинжилгээ	Шинжилгээний хариу
Эхний шинжилгээ	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут	- Хамар залгиурын эрчдас - Ам залгиурын эрчдас - Бусад	- Хурдавчилсан төст - Бх-ПГУ-ын шинжилгээ	- Сөрөг - Зөрөг
Даятан шинжилгээ - 1	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут	- Хамар залгиурын эрчдас - Ам залгиурын эрчдас - Бусад	- Хурдавчилсан төст - Бх-ПГУ-ын шинжилгээ	- Сөрөг - Зөрөг
Давтан шинжилгээ - 2	___ он ___ сар ___ өдөр ___ цаг ___ минут	- Хамар залгиурын эрчдас - Ам залгиурын эрчдас - Бусад	- Хурдавчилсан төст - Бх-ПГУ-ын шинжилгээ	- Сөрөг - Зөрөг